

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-36
<hr/>	
1. Хүний эрхийн дэд хорооны 2025 он, 2026 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан	8-12
2. “Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	13-15
3. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт болон “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	16-33
4. “Журам шинэчлэн батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	33-36
<hr/>	

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
4 дүгээр сарын 29-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 28 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 53.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 30 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Д.Цогтбаатар, Л.Мөнхбаатар;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Батшугар, Д.Батлут, Б.Дэлгэрсайхан,
Б.Пүрэвдорж, Б.Тулга.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд хэлэлцэх асуудлын 5 дугаарт байгаа Хүний эрхийн дэд хорооны 2025 он, 2026 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан, 6 дугаарт байгаа “Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын 1, 2 дугаарт хэлэлцэх горимын санал гаргав.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Хүний эрхийн дэд хорооны 2025 он, 2026 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт, “Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг 2 дугаарт хэлэлцэхээр тогтов.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт, “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь хоорондоо уялдаа холбоотой асуудал тул нэгтгэн хэлэлцэх горимын санал гаргав.

Л.Соронзонболд: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул дээрх 2 асуудлыг нэгтгэн хэлэлцэхээр тогтов.

Нэг.Хүний эрхийн дэд хорооны 2025 он, 2026 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хүний эрхийн дэд хорооны 2025 он, 2026 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайланг Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Баярбаатар, С.Одонтуяа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хүний эрхийн дэд хорооны 2025 он, 2026 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлантай танилцав.

Уг асуудлыг 14 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төсөл болон нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Эрдэнэболд, М.Нарантуяа-Нара нар үг хэлэв.

Л.Соронзонболд: Хүний эрхийн дэд хорооны даргаар Хүрэлбаатарын Баасанжаргалыг сонгож, Сүхбаатарын Эрдэнэболдыг чөлөөлөхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баттулгын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул хуралдааны тэмдэглэлд саналаа дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 14 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны

тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт болон “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төсөл болон ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч С.Эрдэнэболд танилцуулав.

Тогтоолын төсөл болон ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, П.Сайнзориг, Х.Баасанжаргал, Х.Тэмүүжин, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Х.Тэмүүжин нар хариулж, тайлбар хийв.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын гишүүн Б.Тулгын гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмэх:

“1.Эрүүдэн шүүх гэмт хэрэг үйлдсэн этгээдийг төрийн албанд ажиллуулахгүй байх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь хэсэгт заасан төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах нийтлэг шаардлагад эрүүдэн шүүх гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх гэсэн нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

2.Хэлмэгдсэн иргэдийн гаргасан өргөдөл, гомдолд үндэслэн хийсэн шинжилгээ, шинжээчийн дүгнэлтээр эрүүдэн шүүсэн, хүний эрхийг зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсонтой холбогдуулан:

а/тухайн иргэдийн эрх зөрчигдсэн нөхцөл байдлыг тогтоож, дүгнэлт гаргах, нийтэд ил тод мэдээлэх үүрэг бүхий ажлын хэсэг, эсхүл түр хороо байгуулах;

б/уг ажлын хэсэг, түр хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн тухайн хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын үндэслэлээр дахин хянан шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулах.

3.Эрүүдэн шүүх болон хүний эрх зөрчсөн байж болзошгүй хэрэг, маргааныг хянан шалгах, дахин хянан шийдвэрлэх ажиллагааг хөндлөнгийн нөлөөгүй, хараат бус байдлаар явуулах эрх зүйн орчин нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 16

Бүгд: 20
20.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Л.Соронзонболд: “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүд Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцав.

Уг асуудлыг 15 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Журам шинэчлэн батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгээс бэлтгэсэн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баярбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Соронзонболд: “Журам шинэчлэн батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Уянгахишиг хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахад мэдээлэл дутуу байгаа тул хойшлуулах горимын санал гаргав.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 9

Бүгд: 20

55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулав./16:05/

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 35 минут үргэлжилж, 28 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ГАЗРЫН

ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Соронзонболд: Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. 28 гишүүн байх ёстойгоос 15 гишүүн ирцэд орж, 53,6 хувийн ирцтэй байна. Өнөөдөр Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хүрэлбаатарын Баасанжаргал, Халтмаагийн Баттулга, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Даваахүүгийн Пүрэвдаваа, Пүрэвжавын Сайнзориг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Саруулсайханы Цэнгүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүд хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, санал, дүгнэлт гаргах шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт.

2.“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил,, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Уг тогтоолын төслийг дээрх ажлын хэсгийн санал дүгнэлттэй холбогдуулан боловсруулсан тул 1, 2 дахь асуудлыг хамтатган хэлэлцэнэ.

3.Байнгын хорооны тогтоолын төсөл “Журам шинэчлэн батлах тухай”

4.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025 оны 7 сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

5.Хүний эрхийн дэд хорооны 2025 он, 2026 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан

6.Байнгын хорооны тогтоолын төсөл “Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай”

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Эрдэнэболд гишүүний микрофоныг нээе.

С.Эрдэнэболд: Хэлэлцэх асуудлын 5, 6 дээр байгаа асуудлыг 1, 2-ыг нэгтгэсний араас 3 дахь асуудал болгоод хэлэлцэх горимын санал гаргаж байна.

Дэд хорооны тайлан, даргын сонгуулийг ирц өндөртэй байгаа дээр нь явуулчих нь зөв байх л гэж бодож байна.

Л.Соронзонболд: Эрдэнэболд гишүүний микрофоныг нээе.

С.Эрдэнэболд: Тэгвэл эхний асуудал болгоод 5, 6 дугаар асуудлыг нэгтгээд шийдчихмээр байна. Тийм горимын санал гаргаж байна. Тайлангаа тавиад, араас нь болохоор дэд хорооны даргын сонгууль болох учраас. Одоо жишээлбэл давхар ажлын хэсгүүд хуралдаж байгаа юм. Галбадрах гишүүний ажлын хэсэг энэ тэр гээд. Тэгээд нөгөө гишүүд ирцдээ орчхоод, ажлын хэсгүүд рүү орчихоор энэ сонгууль явуулах гэхээр ирц нь уначхаж магадгүй гэж бодоод, олон удаа хойшилж байгаа асуудал учраас эхэндээ шийдчихмээр байна л гэсэн горимын санал гаргаж байгаа юм.

Л.Соронзонболд: Эрдэнэбат гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Бүгдээрээ санал хураалтаа бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Эрдэнэболд гишүүний гаргасан горимын саналаар 5, 6 дахь асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын 1, 2 дугаарт оруулъя гэдэг горимын саналыг Эрдэнэболд гишүүн гаргасан. Тэгэхээр Эрдэнэболд гишүүний саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Эрдэнэболд гишүүний горимын санал буюу 5, 6 дахь асуудлыг 1, 2 дугаар асуудалд оруулах санал дэмжигдлээ. 68,8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудлын 1, 2 дугаарт байсан бол 3, 4-д орж байгаа. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, санал, дүгнэлт гаргах шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт, “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл 2 нь хоорондоо уялдаа холбоотой асуудал тул нэгтгэн хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын саналыг гаргаж байна. Тийм учраас энэ асуудлыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Бүгд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт. 16 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 62,5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудлыг баталсан тул хэлэлцэх асуудалдаа оръё.

1.Хүний эрхийн дэд хорооны 2025 он, 2026 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайланг танилцуулна.

Эрдэнэболд гишүүний микрофоныг нээе.

С.Эрдэнэболд: Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилж дэлгэрэнгүй тайлан хүргүүлсэн учраас товчилсон байдлаар тайланг явъя. Дэлгэц дээр давхар презентаци танилцуулга зэрэгцээд явна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2025 он болон 2026 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайланг та бүхэнд танилцуулж байна. Тайлант хугацаанд Дэд хороо нийт 4 удаа хуралдаж, 22 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 470 гаруй оролцогчийг хамруулсан.

Мөн иргэд, төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагаас ирүүлсэн 124 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 121-д нь хариу хүргүүлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллалаа.

Дэд хороо 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, нийт 19 чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь хүний эрхийн хамгаалал, хяналт, үнэлгээ, бодлогын нөлөөллийг сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ болсон. Энэ хүрээнд цагдан хорих болон тусгай байгууллагын нөхцөл байдалд хяналт тавих, хүүхдийн эрхийн хамгааллыг бэхжүүлэх, хилс хэрэг, цагаатгалтай холбоотой асуудлыг судлах, гадаадад байгаа иргэдийн эрхийг хамгаалах, төрийн бодлого, үйл ажиллагаанд хүний эрхийн суурь зарчмыг шингээх зэрэг чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулсан.

Ялангуяа 2025 онд гадаад улс дахь Монгол Улсын иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэд хорооны тогтоол баталж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, дипломат төлөөлөгчдийн байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэдэд чиглэсэн мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах бодлогын арга хэмжээг тодорхойлсон нь онцлох ажил болсон. Солонгос Улс дахь асуудлыг ярьж байна.

Түүнчлэн дэд хороо парламентын үндсэн чиг үүрэг болох хууль тогтоох, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаандаа иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог бодитоор хангах шинэ механизмыг бүрдүүлэн ажилласан. Тодруулбал 50 гаруй иргэний нийгмийн байгууллагыг нэгтгэсэн хүний эрхийн форумтай сар бүрийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах тогтолцоог бий болгосон. Сар болгоны 2 дахь 7 хоногийн Лхагва гаргийн өглөөний 10 цагаас энэ уулзалтыг тогтмолжуулж хийсэн. Энэхүү механизм нь парламентын шийдвэр гаргалтад олон талт оролцоог хангах бодлогын шийдвэрийг бодит мэдээлэл, нотолгоонд тулгуурлах, парламентын хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх, ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх зэрэг ач холбогдолтой бөгөөд парламентын хяналтын үйл ажиллагаанд чанарын шинэ ахиц авчирсан гэж үзэж байгаа.

Мөн дэд хороо нийгэмд тулгамдсан хүний эрхийн асуудлуудаар идэвхтэй хяналт хэлэлцүүлэг өрнүүлсэн. Эндээс хэдэн жишээг хэлэхэд агаарын бохирдол ба эрүүл орчинд амьдрах эрхийн асуудлаар, гэр бүлийн хүчирхийлэл, хамгааллын тогтолцооны асуудлаар, орон байрны эрхийн хэрэгжилтийн асуудлаар мөн явган зорчигчийн аюулгүй байдлын асуудлаар, цагдаагийн байгууллагын хүний эрхэд суурилсан үйл ажиллагаа зэрэг асуудлаар төр, иргэний нийгэм, мэргэжлийн байгууллагуудын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох санал, чиглэлийг гарган ажиллалаа.

Мөн 2026 оны төлөвлөгөөгөөр нийт 21 зорилгыг тодорхой шалгуур үзүүлэлт, гарах үр дүн, нөлөөллийн хэмжүүртэй нь хамт баталж, үйл ажиллагааны хэрэгжилтийг зөвхөн гүйцэтгэлээр бус бодит үр дүн, нөлөөллөөр нь үнэлэх тогтолцоог бүрдүүлэн ажиллалаа. Өөрөөр хэлбэл зорилт бүрийн хяналт шалгалтын тоо оролцогчийн хамрагдалт, батлагдсан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн хувь, илэрсэн зөрчил бууралтын түвшин зэрэг тоон болон чанарын үзүүлэлтээр

хэмжихээр тусгасан нь төлөвлөгөөний хэрэгжилтийг илүү бодит, хариуцлагатай, үр дүнд чиглэсэн байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байгаа.

Дүгнэж хэлбэл тайлант хугацаанд Хүний эрхийн дэд хороо нь хүний эрхийн хамгаалал, парламентын хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх, иргэний нийгмийн оролцоог бодитойгоор хангах чиглэлээр тодорхой ахиц, үр дүнг гарган ажилласан гэж үзэж байгаа. Цаашид дэд хороо нь хүний эрхэд суурилсан хууль тогтоомж бодлогын хэрэгжилтийг илүү гүнзгийрүүлэх, хяналтын механизмын үр нөлөөг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтын нотолгоонд суурилсан, ил тод, хариуцлагатай болгоход анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Ингээд 2024 оны тайланг 2025 оны 12 сард тайланг тавьсан. Ингээд 2025 он болон нэгэнт дэд хорооны даргын асуудал дараагийн хүнд шилжих гэж байгаа нөхцөл байдал байгаа учраас 2026 оны эхний улирлын тайланг та бүхэнд тавилаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Соронзонболд: Тайланг танилцуулсан Хүний эрхийн дэд хорооны дарга Сүхбаатарын Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Хүний эрхийн дэд хорооны тайлантай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Юун түрүүнд Эрдэнэболд даргад бас цаашдынх нь ажилд амжилт хүсье. Ер нь зүгээр өнгөрсөн цаг хугацаанд Хүний эрхийн дэд хороог идэвхтэй үйл ажиллагаа явуулахад өөрийн санаачилга гаргаж ажиллалаа. Мэдээллүүдийг тогтмол солилцох, энэ дээр тодорхой арга хэмжээнүүдийг авах ажил дээр би бол хувьдаа санаачилгатай ажилласан гэж боддог. Зүгээр нийгэмд үүсчхээд байгаа тулгамдсан хэд хэдэн асуудлыг барьж авсан л даа. Тэр иргэд гадаад улс руу зорчих үйл ажиллагаа дээр манай дипломат алба ажиллах хандлага, арга зүйгээ өөрчлөх энэ асуудлыг хөндөж, нэлээн томоохон хэлэлцүүлэг хийсэн. Би зүгээр гадаад харилцааны асуудал дээр нь болгоомжтой хандаарай гэдэг саналыг тухайн үедээ хэлж байсан.

Дээрээс нь эрүү шүүлтийн асуудал дээр бол маш юу гэдэг юм бэ дээ галыг барьж, тодорхой ажлын үр дүнгээ ч гэсэн Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд уг нь бэлтгээд байгаа. Энийг нь бол үнэхээр хэлж ярих ёстой.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүнийг эрүүдэн шүүх энэ асуудал бол нэлээн Монголд онцгой зарим нэг кэйсүүд бол гарсан. Хохирогчдын тоо тодорхой түвшинд ч яригдсан. Бид хэд хамтдаа нэг хэлэлцүүлэг хийсэн, сонсгол хийсэн. Энийг ажил болгохыг олон хүмүүс хараад байж байдаг юм байна лээ. Тэгээд яах вэ, зүгээр тодорхой тооны хууль, эрх зүйн талын болоод зохион байгуулалтын асуудлыг сайжруулах асуудлууд байгаа гэдэг бол ерөнхий дүгнэлтүүд бол байгаа. Тэгээд энэ дээр Эрдэнэболд даргын энэ хийж байсан ажлыг манай Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо цаашдаа идэвхтэй, зогсоочихгүйхэн шиг ажиллах ёстой шүү гэдэг зүйлийг энэ ташрамд хэлэх гэж байгаа юм.

Тэгээд мэдээж Байнгын хорооноосоо ямар гараад явах гэж байгаа биш, дараагийн хүнтэйгээ сайхан хамтраад ажиллах байх. Тэгээд олон зүйл дээр хүний эрхийн мэдрэмжтэй ажилласан энэ залуу даргад цаашдынх нь ажилд амжилт хүсье гэж ерөнхийд нь товч хэлээд, дараагийн авах хүн маань тэр өмнөх хийж байсан ажлуудыг битгий зогсоогоод, унтуулаарай. Тэгээд илүү энийг бодлогын шийдвэр

болгож, тэр дутагдаад байгаа хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, тодруулах, сайжруулах чиглэлд идэвхтэй ажиллаарай гэдэг зүйлийг энэ ташрамд хэлчихье гэж бодож байна. Тэгээд танд амжилт хүсье. Эрдэнэболд даргад.

Л.Соронзонболд: Одонтуяа гишүүнийг нэмье. Асуулт асууж, үг хэлэх жагсаалтад. Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: 2 асуудлыг нөгөө хамтатгаад хэлэлцэж байгаа учраас үг хэлэх нь зөв болов уу гэж бодож байна. Эрдэнэболд гишүүн бол өнгөрсөн 2 жилийн хугацаанд Хүний эрхийн дэд хороог сайн удирдаж ажилласан. Их идэвхжүүлсэн. Дээр нь энэ нийгэмд тулгамдаад байгаа энэ хүний эрхийн зөрчилтэй холбоотой олон асуудлыг гаргаж ирж тавьсан. Өнөөдөр тайлан бол сайн тайлан орж ирж танилцуулагдлаа гэж үзэж байна.

Тэгээд ер нь энэ Үндсэн хуулийн хүний эрхийн заалтуудыг ер нь яаж амилуулах вэ гэдэг асуудал их чухал байгаад байгаа юм. Наанадаж энэ эрүү, иргэн, захиргааны шүүхээс гарч байгаа энэ шүүхийн тогтоолууд дээр бид нар энэ Үндсэн хуулийнхаа энэ хүний эрхтэй холбоотой зүйл заалтыг үндэслэж асуудлаа гаргаж баймаар байгаа юм. Эрүү, Иргэний хууль, Захиргааны хуулийн холбогдох заалтуудыг бол үндэслэж шийтгэх тогтоолыг бол гаргаж байгаа. Тэгэхдээ үүний өмнө заавал бид нар Үндсэн хуулийнхаа заалтыг оруулж баймаар байгаа юм. Хүний эрхтэй холбоотой. Энэ шүүхийн шийтгэх тогтоолууд чинь бүгд л хүний эрхтэй холбоотой асуудал шийдэж байгаа учраас. Үндсэн хуульчлагдсан хууль гэж Үндсэн хуулийн зүйл заалтаас ургаж гарсан бусад хуулиуд дээрээ эшлэл татахаасаа өмнө заавал эхлээд энэ эцэг хуулиа, Үндсэн хуулиа барьж асуудалд хандаж байх нь зөв болов уу гэж бодоод, дараагийн сонгогдох даргад нь би энийг захиж хэлж байгаа юм.

Өнөөдөр манай парламентад бол яг хүний эрх чиглэлээр мэргэшээд амжилттай ажиллаж байгаа хуульчид байгаа учраас энэ бүрэн эрхийн хугацаанд энэ асуудал дээр нэлээн онцгой анхаарах болов уу гэсэн итгэл үнэмшил бол дүүрэн байгаа.

Тэгээд 2 жил дэд хороог удирдсан Эрдэнэболд гишүүндээ ажлын амжилт хүсье. Дараагийн сонгогдох даргад бол мөн Сайнзориг гишүүнтэй адил саналтайгаар энэ ажлыг улам эрчимжүүлж, нэлээдгүй үр дүнг гаргаж ажиллаарай гэдэг хүсэлтийг уламжилъя. Баярлалаа.

Л.Соронзонболд: Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Эрдэнэболд дарга 2 жил Хүний эрхийн дэд хороон даргаар ажиллалаа. Үнэхээр сайн ажиллалаа гэж үзэж байна. Учир нь бол өмнө нь дэд хороонууд жоохон бүдгэрээд, хавсарга маягаар яваад, ажлууд нь сайн болдоггүй байсан бол энэ удаа бие даагаад чухал чухал асуудлуудыг шийдвэрлэхэд сайн ажиллалаа гэж харж байгаа.

Миний хувьд бол надад 2 асуудал дээр маш их тусалж, хамтарч ажиллаж, их олон төрлийн судалгаануудыг гаргаж өгөхөд дэмжиж ажилласан.

1 дэх нь юуны асуудал вэ гэхээр яг энэ эрүүдэн шүүхтэй холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг дараа 7 хоногт 1 хууль өргөн барих гэж байгаа. Энэ хууль дээр бол Эрдэнэболд дарга бүх талын туслалцаа үзүүлсэнд маш их баярлалаа. Энэ хууль Улсын Их

Хурлаар ороод батлагдах юм бол цэргийн ангиуд дээр гарч байгаа энэ гэмт хэргийн асуудал, нас баралтын асуудал бол бараг байхгүй болно гэж бид зүгээр урьдчилж харж байгаа. Та нар өнөөдөр ч гэсэн хэвлэлээр харсан байх. Бас 1 цэргийн алба хааж байгаа залуус өөрийгөө егүүтгэсэн байх магадлалтай нас барсан гэж. Тэгэхээр энэ цэргийн байгууллагуудын асуудал бол Хүний эрхийн Үндэсний Комиссын тэр хуульд яг эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа явуулдаг газруудын тоонд байдаггүй байсан учраас ийм хэргүүд нэлээн гардаг. Одоо тэрийг байдаг болгоод, бид дараа 7 хоногт энэ хуулиа өргөн барих гэж байгаа.

2 дахь асуудал бол энэ үе тэнгийн дээрэлхэлтэй холбоотой асуудал дээр нэлээд олон талаар чиглэлээр зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлж ажилласан байгаа. Энэ бол нэлээд амаргүй, нийгмийг цочроосон ийм асуудлууд байгаа учраас би Эрдэнэболд даргыг даргынхаа ажлыг өгчихсөн ч гэсэн энэ асуудал дээр сайн хамтарч ажиллаад өгөөрэй. Энэ кэйсүүдийг яг судлаад үнэхээр энэ хэрэгт шалгагдаж байгаа хүмүүс нь яг зохих ял шийтгэлээ авсан юм уу эсвэл энэ нь болохгүй байгаа юм уу, болж байгаа юм уу. Цаашдаа хөнгөн байгаа юм уу, хүнд байгаа юм уу, хүүхдүүдийг яг ингэж асуудлыг нь шийдэх нь зөв юм уу, буруу юм уу гэдэг дээр сайн ажиллаж өгөөрэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Л.Соронзонболд: Хүний эрхийн дэд хорооны тайлантай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Хүний эрхийн дэд хорооны 2025 он, 2026 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа.

14.47 цаг.

Дараагийн асуудалд оръё.

“Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай” Хууль зүйн байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Хүний эрхийн дэд хорооны даргад нэр дэвшигчийг танилцуулъя.

Хүрэлбаатарын Баасанжаргал 2004 онд Их засаг Их сургуулийг эрх зүйч мэргэжлээр, бакалавр зэрэгтэй төгссөн. 2009 онд СЭЗДС-ийг бизнесийн удирдлага мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн. 2019 оноос МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант.

Ажлын туршлага. 2006 оноос өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2006 онд авч ажиллаж эхэлсэн. 2009-2011 онд “Сувд Партнерс” хууль зүйн фирмд өмгөөлөгч, 2010-2011 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнд “Хуульчийн ёс зүй” хичээлийн сургагч багш, Өмгөөлөгч үйлчлүүлэгчийн ашиг сонирхлын зөрчил, Хуульчийн хандлага сэдвүүдээр хуульчдын давтан сургалтын хичээл орж байсан. 2011-2013 онд “Легал Вэй” хууль зүйн фирмийн ахлах хуульч, өмгөөлөгч, 2013-2019 онд өмгөөллийн “И Эл Си” ХХНөхөрлөлийн гишүүн, ахлах хуульч, өмгөөлөгч, 2020 оноос “Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллагад өмгөөлөл, нөлөөллийн зохицуулагч, 2022 оноос Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн төрийн бус байгууллагын захирал, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна.

Нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Нарантуяа-Нара гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баасанжаргал гишүүндээ амжилт хүсье. Би бол яах вэ, сая нөгөө ерөнхийдөө хэлчихсэн. Эрдэнэболд дарга хэд, хэдэн хүнд сэдэв хөндөж яваад, үүнтэй холбоотой бодлогын асуудлыг Улсын Их Хурлаар тогтоол гаргаж, Засгийн газарт үүрэгжүүлж тодорхой хууль, эрх зүйн орчныг сайжруулах асуудал яригдаж байгаа. Ер нь зүгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүний эрхийн зөрчил бол нэлээдгүй байгаа. Та энэ дээр ч гэсэн илүү мэргэшиж дуугардаг. Би энэ салбараасаа гадна ер нь зүгээр та цаашдын үйл ажиллагааны чиглэлд жоохон бизнес эрхэлж байгаа хүмүүсийн асуудал, энийг дагасан хүний эрхийн зөрчлийн асуудлууд дээрээ анхаармаар байна. Яг үнэндээ хэлэхэд нөгөө физикли асуудлыг л хүний эрхийн зөрчил гээд л түргэн шуурхай ч юм уу бид хэд анхаарал хандуулаад байгаа боловч яг энэ Монгол Улсад хүний өмчлөх эрхтэй холбоотой энэ асуудлууд шат шатандаа зөрчигдөх энэ байдал бол байна. Өмчийн асуудал ганхаад ирвэл бүх асуудал ганхдаг. Аль ч нийгэмд. Тэгэхээр энэ дээр бид хэд нэг суурь асуудал буюу энэ бизнесийн эрх зүйн орчныг л сайжруулах асуудал цаана нь ярих гээд байна л даа. Тэгээд энийг бид нар тодорхой хүний эрхийн шалгуураар нь бизнесийн хууль тогтоомжийг авч үзэх, энийг ажлын төлөвлөгөөндөө оруулж үзээч гэж хүсэж байгаа юм. 1 дүгээрт.

2 дугаарт энэ хөдөө орон нутагт байгаа малчин залуучуудын асуудлыг хүний эрхийн талаас нь бид хэд хармаар байна. Сүүлийн үед жендер гээд яахаар яах вэ зүгээр би хүйсээр ялгаварлаж байгаа зүйл биш шүү. Бодит байдал ярьж байгаа учраас та зөвөөр ойлгоорой. Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал ч гэдэг юм уу шат шатны албан тушаалд л очих асуудлыг бид хэд жендерийн асуудалтай холбож ярьсаар байгаад ийм ойлголт юм байна гэдэг олон нийтэд ерөөсөө суучихсан юм билээ. Гэтэл цаана нь ингэж явсаар байтал эрчүүдийн боловсролын асуудал, эрчүүдийн эрүүл мэндийн асуудал ч гэдэг юм уу маш олон зүйлүүд нь сүүлдээ энэ хүн ам зүйн бодлогын томоохон ноцтой үр дагаварт орчихлоо. Тэгээд энийг ерөөсөө бодлогын түвшинд хүн хүний эрхийн зөрчил гэдэг талаас нь одоогоор бол харж хандах байдал бол төрийн бодлогын юун дээр бол дутмаг байгаа шүү. Яг үнэндээ хэлэхэд малчин залуучууд гэр бол болох хүн олдохгүй байна. Эрүүл мэндийн асуудал маш хүнд байна. Эргээд энэ хэдийгээр сайн дурын хөдөлмөр мал маллаад ингээд явж байгаа боловч энийг дагасан нийгмийн маш олон асуудал тэр хүний хувь этгээдтэй нь холбоотой асуудлууд бол үүссэн. Тэгэхээр энийг бид нар нэг бодлогын түвшинд манай Хууль зүйн байнгын хороо бас анхаармаар байна гэдэг зүйлийг хэлмээр байна.

Дараагийн 1 асуудал байна. Энэ яах вэ, зүгээр байгаль орчны асуудал. Тэгэхдээ энэ байгаль орчин ба хүний эрх гэдэг ийм уялдаатай сэдвийг ерөнхийдөө олж харахгүй байна. Тэгээд бүгд л байгаль орчны асуудлыг дур дураараа ярьдаг боллоо..../минут дуусав/

Л.Соронзонболд: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Тэгээд нөгөө ажлын шилжилт явагдаж байгааг зарим хүмүүс ямар учиртай юм гээд асуугаад байгаа. Тэгээд энэ бол сайн дурын цэвэр, ер нь итгэл үнэмшлээр шилжүүлэн өгч байгаа шүү. Өөрийн хүсэлтээр гэж байгаа шүү. Яагаад тэгж байгаа вэ гэхээрээ 2024 оны 10 сарын 22-ны өдөр миний бие энэ ажлыг авахдаа тухайн үед нөгөө хамтарсан засаг явж байсан. Тэгээд 2, 2 жилээр нь

ээлжлээд явна гэсэн ийм ойлголцолтой байсан учраас яг энэ үгэндээ суугаад, санаачилгаараа Хууль зүйн байнгын хорооны хурлаар энэ асуудлыг хэлэлцэж өгөөч гэж Улсын Их Хурлын дарга болон Байнгын хорооны даргад хүсэлт тавиад ийм болж байгаа юм шүү гэдгийг та бүхэн зөв ойлгоорой.

Тэгээд өмнөх дэд хорооны хурлууд дээр дэд хорооныхонтойгоо энэ асуудлыг ярилцсан юм байгаа юм. Тэгээд манай дэд хорооныхондоо би онцгойлон талархал илэрхийлмээр байна. Манай Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, дээрээс нь Баярбаатар гишүүн, манай Баасанжаргал гишүүн, Номинчимэг гишүүн, Сайнзориг гишүүн, Одонтуяа гишүүн, манай Баттулга гишүүн байж байна. Тэгээд Тэмүүжин гишүүн байж байна, тэгээд сүүлд бас Баярмаа гишүүн орсон. Уянгахишиг гишүүн орсон. Дээрээс нь манай Отгонбаяр гишүүнд бас талархаж байгаа. Манайд байсан Сандагаа гишүүн танд баярлалаа. Тэгээд ийм байгаа юм. Ер нь зүгээр хүний эрхийн асуудал ярихаар Баасанжаргал гишүүн ээ, бид нар урьд жил нөгөө агаарын бохирдлын юм хийсэн шүү дээ. 5 салбар хорооны хурал хийгээд, тэгээд яг нөгөө хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх гээд л ярингуут тэнд бөөн хэлэлцүүлэг, сонсгол болоод л тэгээд л байхгүй. Амарбаясгалан даргыг Их Хурлын дарга байхад нь хүн төвтэй шийдвэр гаргана. 5 шалгуур гээд л баталсан. Тэгээд л байхгүй. Тэгээд ингээд юм батлаад, араас нь нөгөө Implementation буюу хэрэгжүүлдэг механизм маш сул юм байна.

Баттулга гишүүн жишээлбэл ороод би 10 дахь хүний эрхийн дэд хорооных нь дарга. 2008 оноос хойш. Тэгэхэд яг ингээд архив шүүгээд ухахаар Ё.Отгонбаяр гишүүн л яг зорилго, төлөвлөгөө гаргаад, тэрнийхээ тайланг тавьж байсан юм нь одоо архивд байна. Бусад дэд хорооны дарга нарын хувьд дэд хорооны тайлангууд ерөөсөө хэлэлцэгдэж байгаагүй. Архивд байхгүй учраас их хэцүү болчихоод байгаа юм. Би нөгөө хүмүүсийг үгүйсгэж байгаа юм биш шүү дээ. Тэгэхээр энэ дээр яасан гэхээрээ анхнаасаа Баасанжаргал гишүүнийг яг ерөөсөө бүх уулзалтдаа хамт оролцсон. 10 уулзалт болохоос 10-ууланд нь Баасанжаргал гишүүн бүгдэд нь оролцож явсан. Өөрөөр хэлбэл нөгөө дараа нь үргэлжлүүлээд ингээд санах ой байх ёстой. Намын харьяалал өөр. Тэр хамаагүй. Хүний эрхийн асуудал гэдэг чинь намын өнгө хамаарахгүй, Монгол Улсын Үндсэн хуулиар эдлэх ёстой Монгол хүний эрх учраас ингээд ер нь бол бид нар хамтарч ажилласан юм. Тэгээд жилд 2 удаа хуралддаг, 4 удаа хуралддаг байсныг бид нар сар болгон ингээд асуудал дэвшүүлдэг болгож, сошиал сувагтай болгож, тэгээд бүх аймгийн ИТХ руу хүний эрхийн мэдрэмжтэй шийдвэр гаргаач ээ гэж шаардлага эд нар тавьж нэлээн ажилласан. Тэгээд энэ дээр манай Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн ч гэсэн эмэгтэй хүнийхээ хувьд манлайллын хувьд нэлээн сэдвүүдийг .../минут дуусав/

Л.Соронзонболд: Эрдэнэболд гишүүнд 1 минут нэмж өгье.

С.Эрдэнэболд: Тэгээд Одонтуяа гишүүн ч гэсэн түрүүний хэлж байгаа асуудлууд байна. Цэнгүүн гишүүн эд нартай нөгөө манай дэд хороонд ороогүй байхад нь бид нар нөгөө Ноорог-ийн асуудал эд нар гээд ер нь улс төрийн галтай асуудлууд дээр тодорхой байр сууриуд илэрхийлж, Үндсэн хуулийн зарчмын дагуу Баярбаатар гишүүний хэлж байгаачлан ингэж ажилласан. Тэгээд одоо өнөөдрийн хурлаар орох гэж байгаа тэр нөгөө эрүү шүүлттэй холбоотой дүгнэлт, тайлан, тогтоолын төсөл ч гэсэн манайх багаараа хийсэн юм шүү. Тэгэхээр анх бол 2024 онд бол манай Хууль зүйн байнгын хороо 22 гишүүнтэй байснаас 9 нь Хүний эрхийн дэд хороонд байсан. Өнөөдөр бол 27 гишүүнээс 10 нь дэд хороонд байна. Тэгээд энэ ганцаараа хийдэг ажил биш учраас цааш цаашид нь Баасанжаргал гишүүнийг сонгогдсон тохиолдолд дэмжиж ажиллана. Энэ дээр ямар нэгэн байдлаар нам,

бүлэг, фракц гэсэн ойлголт байхгүйгээр яг Үндсэн хуулийн зарчмын дагуу бид хамтарч ажиллана гэдгээ илэрхийлье. Баасанжаргал гишүүндээ амжилт хүсье.

Л.Соронзонболд: Нарантуяа-Нара гишүүн.

М.Нарантуяа-Нара: Баярлалаа. Өдрийн мэнд хүргэе та бүхэнд. Өмнөх дэд хорооны дарга Эрдэнэболд даргатайгаа хамтарч ажиллахад маш таатай байсан. Үнэхээрийн манлайлал, чин сэтгэл, зүтгэл бүх сэтгэлээ дайчилж ажиллаж байсныг дурдъя. Тэгээд танд бас баярлалаа. Тэгээд шинээр санал оруулж байгаа Баасанжаргал гишүүнийг дэмжиж байна. Тэгээд мэдээж Баасанжаргал гишүүний хувьд бол мэдлэг туршлага, онол практик маш сайхан хослуулаад аваад явна гэдэгт итгэж байна. Одоо ялангуяа хүний эрх дундаа нэг зүйл ер нь байнга яригдаж байдаг мөртөө гээгдэх гээд байгаа асуудал байгаа. Тэр нь цахим орчин дахь хүний эрх, эрх чөлөөний асуудлыг маш сайн энэ дэд хороондоо авч ажиллаарай гэж хүсэх ийм хүсэлт тавих гэсэн юм. Тэгээд таны ажилд амжилт хүсье. Тэгээд хамтдаа бүгдээрээ дэд хороогоо үргэлжлүүлээд сайн авч явъя. Баярлалаа.

Л.Соронзонболд: Нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлдье.

Хүний эрхийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргалыг сонгож, Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Сүхбаатарын Эрдэнэболдыг чөлөөлөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 19 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 68,4 хувийн саналаар Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүнийг Хүний эрхийн дэд хорооны даргаар сонголоо.

Тэгэхдээ 1 зэрэг явчихсан шүү дээ. Баттулга гишүүнийг дэмжсэнээр авъя.

“Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

Дэд хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хур Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргалыг Хүний эрхийн дэд хорооны даргаар сонгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболдыг Хүний эрхийн дэд хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

“Хүний эрхийн дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалд оръё.

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт болон “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд хийнэ.

С.Эрдэнэболд: Юуны өмнө ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүдээс энд байна. Тэгээд бид нар тогтоолын төсөл танилцуулчаад тодруулах асуултад хариулна.

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт.

Байнгын хорооны хуралдаан даргалагч, эрхэм гишүүд ээ,

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Хууль зүйн байнгын хорооны 10 дугаар тогтоолоор байгуулагдсан.

Уг ажлын хэсгийг Хүний эрхийн дэд хорооны дарга асан миний бие ахлан, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Х.Баасанжаргал, Д.Ганбат, О.Номинчимэг, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг нар ажиллалаа.

Ажлын хэсэг өнгөрсөн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, үйл ажиллагаандаа мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан дараах ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлээд байна. Үүнд:

1.Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх, эрх зөрчигдсэн гэх иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах ажлыг 2025 оны 1 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлүүлж Хууль зүйн байнгын хороо болон Хүний эрхийн дэд хорооны шугамаар нийт 38 иргэний 21 хавтаст хэрэг, 2386 хуудас материалыг хүлээн авсан.

2.Иргэдийн өргөдөл, гомдолд хууль зүйн шинжилгээ хийх, санал, зөвлөмж боловсруулах ажлыг зохион байгуулах зорилгоор Хууль зүйн байнгын хорооноос Хүний эрхийн дэд хорооны даргын даргын даргын саналд үндэслэн судлаач

Ч.Нямсүрэн, М.Эрдэнэбаяр, Ч.Өнөржаргал нартай 2025 оны 2 дугаар сарын 17-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, холбогдох материалыг хүлээлгэн өгсөн.

3.Хууль зүйн байнгын хорооны дэмжлэгээр судлаачдын ажиллах нөхцөл боломжоор хангаж, холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу нууцын баталгаа гаргуулан ажиллуулсан.

4.Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 9 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр криминологийн судалгаа мөн энэ төрлийн гомдол шийдвэрлэгдэхгүй байгаа нөхцөл байдлын талаар хөндлөнгийн судалгааны байгууллагуудаар суурь судалгааны захиалга өгч хийлгэн, уг судалгааг Байнгын хорооны гишүүдэд тараасан. Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулсан.

5.Ажлын хэсгийн ахлагчийн зүгээс Хууль зүйн байнгын хороонд санал болгож 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр А.Дулмаа нарын 3 судлаачтай шинээр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, нийт 6 хэргийн 8 иргэний 156 хуудас материал хүлээлгэн өгч, 2026 оны 3 дугаар сарын 15-ны өдөр холбогдох тайлан, дүгнэлт, зөвлөмжийг хүлээн авсан.

6.Ажлын хэсэг 2026 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр хуралдаж, судлаачдын гаргасан гаргасан тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцсан бөгөөд Хууль зүйн байнгын хороонд дараах санал дүгнэлтийг танилцуулж байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй нийтлэг зөрчил бодлогын арга хэмжээний тухай.

Судалгаанд хамрагдсан тохиолдлуудад хийсэн хууль зүйн шинжилгээний дүнгээс үзэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарч буй зөрчил нь ганц нэг удаагийн процессын алдаа бус давтагддаг, тогтмол шинжтэй институцийн түвшний системийн доголдол байгааг илтгэж байна. Ялангуяа мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хяналт, шүүхийн шатад хүний эрхийн суурь баталгаа болох хууль зүйн туслалцаа авах эрх, хүний халдашгүй байдал, шударга шүүхээр шүүлгэх эрх зэрэг үндсэн зарчмууд бодитоор хангагдахгүй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тэнцвэртэй байх зарчим алдагдаж, яллах чиг баримжаа давамгайлсан шинжтэй хэрэгжиж байна. Иймд уг асуудлыг тус бүрийн хэрэгт илэрсэн зөрчил төдийд авч үзэх боломжгүй бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны бүтэц, үйл ажиллагааны гажуудал, институтийн хяналт, хариуцлагын механизмын сулрал, процессын баталгааны хэрэгжилтийн доголдолтой холбоотой системийн шинжтэй асуудал гэж үзэх нь зүйтэй байна. Тодруулбал:

1.Нотлох баримтын бүрдүүлэлт, үнэлгээний зөрчил, шинжээчийн дүгнэлтийн тухайд нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу бүрэн гүйцэт цуглуулаагүй, нэг талыг барьсан байдлаар үнэлсэн, зарим тохиолдолд хангалтгүй, эргэлзээтэй нотолгоонд тулгуурлан яллах шийдвэр гаргасан байж болзошгүй байна. Мөн хэргийн бодит байдлыг бүхэлд нь тогтооход чиглэсэн өөр боломжит хувилбар, сэжигт таамгийг шалгалгүй орхисон байна. Энэ нь нотлох баримтыг чөлөөтэй үнэлэх зарчмыг гажуудуулж, эргэлзээг яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг зөрчиж, хэргийн бодит үнэнийг тогтоох боломжийг алдагдуулсан гэж үзэж байна.

2.Хууль зүйн туслалцаа авах эрхийн ноцтой зөрчил буюу өмгөөлөгчгүйгээр байцаалт явуулах, шүүх хуралдаан хийх, өмгөөлөгчийг хэргийн материалтай бүрэн танилцуулахгүй байх, өмгөөллийн бэлтгэл хангах боломжийг хязгаарлах зэрэг зөрчил олон удаа давтагдсан байна. Энэ нь эрүүгийн процессын суурь баталгаа болох хууль зүйн туслалцаа авах эрхийг бодитоор хэрэгжих боломжгүй болгож шүүх хуралдааны тэгш оролцооны зарчмыг алдагдуулж байна.

3.Хүний халдашгүй байдал эрүүдэн шүүхийн шинжтэй зөрчил буюу албадан ирүүлэх, баривчлах ажиллагааны явцад хэтрүүлсэн хүч хэрэглэх, бие махбодын гэмтэл учруулах, эрүүдэн шүүсэн гэх гомдолд давтамжтай илэрсэн. Энэ нь хүний эрхийн суурь баталгаа болох эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх эрхийг ноцтой зөрчсөн шинжтэй гэж үзэхээр байна.

4.Хөөн хэлэлцэх хугацааг буруу тооцох, хэрэгсэхгүй болгосон хэргийг хууль зүйн үндэслэлгүйгээр сэргээх, хэрэг хаах шийдвэрийг үндэслэлгүй гаргах зэрэг процессын ноцтой зөрчил гарсан байна.

5.Шүүх прокурорын үйл ажиллагаагаа бодитойгоор ялгах боломжгүй хэмжээнд нэг чиглэлд төвлөрсөн, гаднын нөлөөлөл байж болзошгүй нөхцөл ажиглагдсан байна. Энэ нь шүүхийн хараат бус, бие даасан байдлын баталгаанд эргэлзээ төрүүлж, шударга шүүхийн зарчмын хэрэгжилтийг сулруулж байна.

6.Цагдан хорих арга хэмжээг зайлшгүй шаардлагатай нөхцөлгүйгээр урт хугацаагаар хэрэглэсэн тохиолдлууд нийтлэг байна. Энэ нь уг арга хэмжээний сүүлчийн арга Ultima Ratio байх зарчмыг алдагдуулж, хүний эрх, эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна.

7.Мөрдөгч, прокурор, шүүгчийн зүгээс эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэх, процессын оролцогчдын эрх тэгш байдлыг хангахгүй байх, хэрэг шийдвэрлэхээс илүү яллах чиг баримжаа давамгайлсан хандлага ажиглагдаж байна. Энэ нь эрүүгийн процессын үндсэн зарчим болох оролцогч талуудын тэгш байдал, шүүхийн төвийг сахих үүргийг алдагдуулж, яллах тогтолцооны хэв шинжийг бэхжүүлж байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдал илэрч буй зөрчлүүдийг харгалзан үзэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үүссэн доголдлыг хэсэгчилсэн, тохиолдол бүрээр засах оролдлогоор хязгаарлах боломжгүй бөгөөд бодлогын түвшинд дараах үе шаттай цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

1 дүгээрт, богино хугацаанд хэрэгжих боломжтой арга хэмжээний хүрээнд хууль тогтоомжид чиглэсэн тодорхой зорилтот өөрчлөлтүүдийг сүүлийн жилүүдэд Улсын Их Хурлаар хэлэлцэн баталж, эрх зүйн орчныг тодорхой хэмжээнд бүрдүүлсэн байна. Гэвч судалгааны дүнгээс үзэхэд дээрх зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй, зарим тохиолдолд огт хэрэгжихгүй эсвэл хэв төдий байдлаар хэрэгжиж байгаа нь илэрч байна. Тухайлбал, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн баталгаа бий болсон хэдий ч практикт өмгөөлөгчгүйгээр процессын ажиллагаа явуулах явдал тасраагүй. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь сүүлчийн арга байх зарчмаасаа хазайж өргөн хэрэглэгдсээр байна. Мөн хэрэг хаах, сэргээхтэй холбоотой зохицуулалт тодорхой болсон боловч түүний хэрэглээ жигд бус, хууль зүйн үндэслэлд нийцээгүй шийдвэрүүд гарсаар байна. Иймд цаашид зөвхөн хууль тогтоомжийг өөрчлөхөөс илүүтэйгээр батлагдсан хуулийн хэрэгжилтийг бодитоор хангах, нэг мөр ойлгож хэрэглэх практикийг тогтоох,

хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлагын механизмыг эрс чангатгах шаардлага тул тулгарч байгаа юм.

2 дугаарт, дунд хугацаанд хэрэгжүүлэх институцийн өөрчлөлтийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй процессын зөрчлийг одоогийн дотоод хяналтын тогтолцоонд даатгах боломжгүй нь тодорхой байх тул тэдгээрийг хараат бус бие даасан хяналтын механизмаар шалгаж, үнэлдэг тогтолцоог яаралтай бүрдүүлэх шаардлагатай гэж үзсэн. Үүний зэрэгцээ шүүхийн өмнөх хяналт өнөөдөр хэв маягийн шинж чанартай хэрэгжиж байгааг өөрчлөөд албадлагын арга хэмжээ бүрийг шүүхийн бодит үр нөлөөтэй хяналтад оруулж зөвшөөрлийн шинжтэй бус хариуцлага дагуулдаг хяналтын тогтолцоо болгон төлөвшүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Мөн хууль зөрчиж олж авсан нотлох баримтыг ашиглах явдлыг зөвхөн зарчмын түвшинд бус бодитойгоор хориглож ийм баримтад тулгуурласан аливаа шийдвэрийг хүчингүйд тооцдог хатуу эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч байна. Түүнчлэн парламентын хяналтын чиг үүргийг хэлбэрийн төдий хэрэгжилтээс гаргаж тогтмол зорилтод үр дүнтэй болгох замаар гүйцэтгэх болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд бодитой хариуцлага тооцдог механизмыг бий болгохгүйгээр дээрх зөрчлүүдийг арилгах боломжгүй гэж үзэж байна.

3 дугаарт урт хугацаанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд суурь өөрчлөлт хийхгүйгээр дээр дурдсан зөрчил доголдлыг арилгах боломжгүй нь тодорхой байх тул системийн шинжтэй цогц шинэчлэлийг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай. Өмгөөллийн институцийг формал оролцогч биш бодит хамгаалалтын механизм болгон төлөвшүүлэх, түүний санхүү, мэргэжлийн чадавх бие даасан байдлыг бодитойгоор бэхжүүлэх нь эрүүгийн процессын тэнцвэрийг сэргээх суурь нөхцөл болно гэж үзэж байна.

Мөн шүүхийн хараат бус төвийг сахих байдлыг зөвхөн зарчмын түвшинд бус институцийн баталгаагаар хангаж, аливаа гаднын болон дотоод нөлөөллөөс ангид зөвхөн хуульд захирагдан шийдвэр гаргах орчныг бүрдүүлэх шаардлагатай юм. Түүнчлэн мөрдөгч прокурорын хууль зөрчсөн процессын ноцтой алдаа гаргасан үйл ажиллагаанд бодит зайлшгүй зайлсхийх боломжгүй хариуцлага тооцдог тогтолцоог бүрдүүлэхгүйгээр дээрх зөрчлүүдийг таслан зогсоох боломжгүй бөгөөд хариуцлагагүй байдал нь өөрөө системийн доголыг дахин үйлдвэрлэж буй гол хүчин зүйл гэж үзэж байна.

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл энэхүү асуудлыг үе шаттай хэрэгжүүлэх хосолмол арга замаар шийдвэрлэх нь зүйтэй бөгөөд нэн яаралтайгаар хууль зүйн туслалцаа авах эрхийн баталгааг хангах, цагдан хорих арга хэмжээний хэрэглээг хязгаарлах чиглэлээр арга хэмжээ авах, дунд хугацаанд хараат бус хяналтын механизмыг бий болгож, нотлох баримтын хууль ёсны стандарт, шалгуурыг чангатгах, улмаар урт хугацаанд эрүүгийн процессын тогтолцооны цогц шинэчлэлийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн.

Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй дээрх зөрчлүүдийг системийн шинжтэй гэж үзэж, парламентын түвшинд бодлогын цогц шаталсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүйгээр хүний эрхийн баталгааг хангах, шударга шүүхийн тогтолцоог бэхжүүлэх боломжгүй байна гэж үзэж байна.

Танилцуулж дууслаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн ахлагч Сүхбаатарын Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт, үг хамт явъя. Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүний микрофоныг нээе..

О.Номинчимэг: Баярлалаа. Энэ ер нь эрүүдэн шүүлтийн сонсгол явуулаад бид бас ийм тулгамдсан асуудал байгаад байгаа юм байна гэдэг дээр ажлын хэсэг ажилласан. Тэгээд ер нь мэдээж энэ эрх нь зөрчигдсөн олон иргэдийн гомдол байгаа. Тэгээд Улсын Их Хурал энэ сонсгол явуулсныхаа үр дүнд үр дүнтэй арга хэмжээ авч, иргэдийнхээ асуудлыг шийдье гээд ажлын хэсэг байгуулагдсан. Ер нь бол тэгээд хүний амьдрал богинохон. Олон жил эрх нь зөрчигдөөд, бие сэтгэл, махбодоороо хохирчихсон байгаа хүмүүс цөхрөөд л энэ асуудал бол Улсын Их Хурал дээр яригдаж, бид нар ажилласан. Тэгээд энэ тогтоолын төслийг харахаар ер нь бол энэ тогтоол маань яг тэр хүмүүсийнхээ асуудлыг бол шийдэхгүй, асуудал шийдэх эхлэлийг нь тавьж байгаа юм байна гэж харж байгаа. Ер нь бусад улсын туршлага эд нарыг харахаар би ажлын хэсэгт ажилласан хүний 1 л дээ. Тэгэхээр гол асуудал нь одоо энэ хүмүүсийн чинь шүүхийн шийдвэр нь гарчихсан. 3 шатын шүүх нь дуусчихсан эсвэл давж заалдах хугацаа нь дуусчихсан. Гэхдээ шинжээчдийн дүгнэлтээр ийм алдаа дутагдал байна гээд гарч байгаа юм.

Тэгэхээр мэдээж Улсын Их Хурал бол энэ шүүхийн шийдвэрүүдийг бүгдийг нь автоматаар хүчингүй болгоод, шийдвэр гаргах эрхгүй байгууллага. Гэхдээ энэ яг тухайлсан иргэдийн асуудлыг дахиж хөндлөнгийн нөлөөлөл орохгүйгээр зөв хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах нөхцөлийг нь бүрдүүлээд хууль, эрх зүйн орчин, үгүй тэр чинь ер нь бас хууль, эрх зүйн орчин гэхээсээ илүү фактын асуудлууд байгаа шүү дээ. Тэрийг нь бүрдүүлээд цагаатгах гэдэг юм уу эсвэл дахиад энэ процессыг нь гэм буруугийнх нь үнэхээр байсан юм уу, үгүй юу гэдэг асуудлыг нь шийдэх арга чарга уг нь бол бид хаймаар байгаа юм. Тэгсэн одоо бид нар чинь тогтоол дээрээ бол Засгийн газарт л үүрэг өгчхөж байгаа юм байна шүү дээ. Ийм хууль оруулж ир гээд. Бид нар бол шийдэхгүй гээд. Тэгэхээр энэ дээр ер нь ингээд бүр аргаа ядаад гуравдагч тэр шүүхийн засаглалаасаа ийм байна, бид нарын яг үнэнийг хэлэхэд авч хэлэлцсэн хэргүүд ихэнх нь 2021-2016 онтой холбоотой хэргүүд байгаа. Хэн нэгэн Ерөнхийлөгч гараад л өөрсдийнхөө ойр дотын хүмүүсийг шүүх, прокурор, АТГ дээр тавиад л шударга бусын хонгил, тэр юуны хонгил гэнэ үү ингэчихсэн юмны кэйсүүд байгаа шүү дээ. Ихэнх кэйс байна 2012-2016 оны кэйсүүд байгаа. Тэгэхээр энэ асуудлуудыг ер нь тэгээд Засгийн газар хууль өөрчилж орж ирээд шийдэгдэх юм уу. Эсвэл яг энэ шинжээчийн дүгнэлтээр гарсан хэргүүд дээр дахин хянан шийдвэрлэх ажиллагаа хөндлөнгийн хараат бусаар явуулах нөхцөлийг нь бүрдүүлээд явуулах ёстой юм уу. Аргыг нь олохгүй бол яг бид нар энэ иргэдэд олон жил болчихсон, амьдралынх нь овоо хэдэн жилийг нь авчихсан энэ хүмүүст мөнгөн хохирол гэхээс илүү сэтгэл санааны хохирол ч яригдах, тэрнээс гадна нэр төрөө цэвэрлүүлэх гэдэг асуудал яригдаад байх шиг байгаа юм. Тэгээд энэ дээр цөмөөрөө яах вэ. Энэ тогтоол дээрээ бол Засгийн газарт үүрэг өгчхөж байгаа. Энийг бид нар энэ дээрээ ярилцах арга зам байсан уу, үгүй юу гэдэг дээр тодруулаад асуучихъя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн ахлагчийн микрофоныг нээе. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Яг үнэнээ хэлэхэд бол их л замбараагүй юм болсон юм байна гэж харсан. Энэ хэргүүд дотор мэдээж нууцын зэрэгтэй асуудлууд байсан. Нууцын зэрэгтэй асуудлыг нээлттэй ярьж болохгүй. Гэхдээ ер нь ингээд хүний эрхийн

ноцтой зөрчил, хохирлын асуудлууд бол байгаа. Тэгээд хөөрхий яг тэр хүмүүсийн нийтлэг хүсэлт нь болохоор нэр төрөө таны хэлж байгаа шиг нэр төрөө сэргээлгэх, цэвэрлэх, тэгээд яг нарийн ярих юм бол мөнгөн хохирол төлөгдөнө гэх юм бол энд чинь өчнөөн олон тэрбум төгрөгийн асуудал гарна шүү дээ. Яг тэр эрх зүйн зохицуулалт нь тийм тодорхой биш. Тэгээд бид нарын энэ ажлын хэсгийн даалгавар чинь бол яг энэ дээр л санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл санаачлах гэсэн ийм зүйлээр орж ирсэн. Тэмүүжин гишүүн үүний араас ярих байх. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар дарга яг ийм ижилхэн санаатай байсан. Ер нь ийм юм үүсгээд байгаа, хэлмэгдүүлээд байгаа жишээлбэл ийм субъектүүдэд ер нь ямар хариуцлага байх юм. Ийм хөөн хэлэлцэх хугацаагүйгээр авч үздэг, дахиад хүн хэлмэгдүүлэх нөгөө хуулийн тодорхой цоорхойгоор ч гэдэг юм уу ингээд яваад байгаа энэ нөхцөл байдалд ямар хариуцлага байдаг байх юм. Цаашлаад энийг шийдэхийн тулд эрх зүйн өөрөө дотроо хийдэлгүйгээр ингээд ямар механизм бүрдүүлэх юм бэ гэдэг бодлогын асуудлууд бол байгаа. Тэгэхээр яг одоо саяын энэ кэйсүүд дээр хүн 1 бүрийн холбогдсон хэрэг тус бүр дээр нь одоо ингээд шийдчихье, ингээд шийдчихье гэхээр энэ их учир дутагдалтай байсан байна. Тэгэхээр энэ дээр бол ямар ч байсан дахиад яг чиглэл чиглэлээр нь жоохон эрэмбэлээд, дэс дараалалд оруулаад ийм хуулийн төслүүдийн ажлын хэсгүүд гарах ёстой юм байна гэж үзэж байгаа. Тэр утгаараа энийг жоохон ер нь бол бид нар чинь хараат бус хөндлөнгийн экспертүүдийг тусад нь цалинжуулаад, дүгнэлт гаргаж байгаа шүү дээ. Их Хурлын гишүүдийн субъектив ямар нэгэн санаагүйгээр, яг их сургуулийн багш, тодорхой хүмүүсээс дүгнэлт аваад, энэ дүгнэлтийг үндэслэж бид нар шүүх, прокурор луу ч юм уу ямар нэгэн газар луу нөлөөлөх боломжгүй болчихоод байгаа юм. Харин энэ дүгнэлтийг үндэслэж, тайлангаа боловсруулаад, энэ дүгнэлт дээрээ үндэслэж тэгвэл ямар эрх зүйн орчныг боловсронгуй болгох шийдэх шаардлагатай вэ гэсэн л дүн шинжилгээгээ өнөөдөр танилцуулж байгаа л гэсэн санаа. Тэгэхээр ер нь бол цаашдаа хийх ажил их байна гэж харагдаж байна.

Л.Соронзонболд: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Тогтоолын төслийн 3 дээр яг Засгийн газарт тайлан дээр л ярьж байгаа юу. Тэгвэл уучлаарай тогтоол дээр би хэлье.

Л.Соронзонболд: Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Тогтоолын төсөл хамт явж байгаа юм байна. Тэгэхээр энэ тогтоолын төслийн 3 дээр бид нар чинь хуулийн төсөл боловсруулахыг Засгийн газарт даалгачхаж байгаа юм. Тэн дээр яах вэ, эрх сэргээх гэдэг юм ороод ирж байгаа. Тэгээд нөхөн төлбөр, эрүүл мэнд, сэтгэл зүй. Энэ бол тэр буруу гэдэг нь шийдэгдчихсэн хэргүүд дээрээ явах биз. Тэгэхээр гол нь нөгөө зарим хүмүүсийн хувьд чинь ял авчихсан, эдэлчихсэн. Гэм буруутай гээд тогтоогдсон. Цагаатгах боломжгүй гээд зогсчихоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хүмүүсийн хувьд тэр эрх сэргээх гэдэг асуудал юу болох юм бэ. Яг энэ тухайлсан хүмүүсийн эрхийг сэргээх чиглэлээр яг ямар ямар ажил хийгдэнэ гэж бид төлөвлөж энэ тогтоол дээрээ энийг оруулж байгаа юм бэ гэдгийг тодруулаад асуучихъя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн гишүүн Тэмүүжин хариулна. Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

Х.Тэмүүжин: Энэ бодит тохиолдсон кэйсүүд дээр судалгаа хийгээд, тэгээд эрх нь хөндөгдсөн, эрүү шүүлтэд өртсөн иргэдийн хамгийн их хүсэж байгаа зүйл нь болохоор хэрэг маргаанаа дахин шийдүүлмээр байна л гэдэг, бид нэрээ цэвэрлэж

авмаар байна, хууль бусаар үүрч байгаа ялаа алга болгомоор байна гэдэг ийм хүсэлт тавиад байгаа юм. Энийг ямар арга замаар шийдэх вэ гэдэг шийдэл дээр бол Үндсэн хуулийн арга замууд нь байгаа юм. Бид хууль болгож гаргаж өгөх ёстой. Үндсэн хуулийн цэцэд иргэний үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх чиглэлийнх нь эрхийг тодотгоод, процессыг нь бий болгоод өгчих юм бол энэ чинь Үндсэн хуульд заасан суурь эрх шүү дээ. Угаасаа эрүү шүүлтээс ангид байх гэдэг чинь. Тэгээд энэ эрх нь зөрчигдсөн гэж байгаа иргэн маань шүүхийн 3 шатын шийдвэр гарчихсан байгаа. Тэрний дараа Үндсэн хуулийн шүүхэд хандах замаар асуудлаа шийдүүлээд, тэгээд Үндсэн хууль дээр маш тодорхой заачихсан. Үндсэн хуулийн цэцээс Дээд шүүхэд хүний эрхийн асуудлаар шилжүүлж өгсөн асуудлыг шүүх .../минут дуусав/

Л.Соронзонболд: Нэмж хариулах уу. Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

Х.Тэмүүжин: Үндсэн хуулийн цэцээс хүний эрхийн асуудлаар дээд шүүхэд шилжүүлсэн асуудлыг шүүхийн систем өөрөө засаж шийдвэрлэх ёстой юм. Тэгэхээр Үндсэн хуулийн энэ механизмыг амилуулах хэрэгтэй. Хууль зүйн байнгын хороо дээр энэ асуудлаар ер нь нэн түрүүн ярьсан нь дээр байх. Үндсэн хуулийн цэцийнхэн бол маш тодорхой сүүлийн 10-аад шийдвэр дээрээ иргэний үндсэн эрхтэй холбоотой маргааныг бид аваад хэлэлцээд шийдээд эхэллээ гэдгээ хэлчихсэн. Тийм учраас ямар процессоор энэ нь явах юм бэ гэдгийг тодорхой зааж өгөх ёстой. Тэр процессын дараа Цэцээс Дээд шүүх рүү очвол тэр нь хэрэг маргаанууд нь яаж иргэний үндсэн эрхийн тэр асуудалтайгаа нийцэж шийдвэрлэгдэх юм бэ гэдэг эрүүгийн процессын хуулиуд руу нь зохицуулалтыг нь хийж өгөх ёстой. Тэгэх юм бол энэ хүмүүс бүгдээрээ эрхээ сэргээлгэх боломжтой болчихож байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хууль дээр байж байдаг. Бусад хуулиар нь бид хийж өгөөгүй байдаг. Тэгээд энэ тал дээрээ Засгийн газар бол энэ чиглэлийн хуулийг бол шийдэж орж чадахгүй байх бараг. Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулаад, нэн даруй шийдэх хэрэгтэй.

Л.Соронзонболд: Сайнзориг гишүүнийг асуулт асууж, үг хэлэх гишүүдийн жагсаалтад нэмье. Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Тэгэхээр Үндсэн хуулийн цэцээр хүний үндсэн эрхийн маргаантай холбоотой асуудлыг шийддэг болоод бид нар тэгвэл арга зам нь ийм байна гэж харж байгаа юм байна. Тэгэхээр Үндсэн хуулийн цэц чинь хүний үндсэн эрхийн маргаан шийдвэрлэдэг болохын тулд та Үндсэн хуулийн цэцийн хуульдаа л өөрчлөлт оруулчихна гэж бодож байна уу. Үндсэн хууль дээрээ өөрчлөлт оруулахгүйгээр тэрийг байх хаалга нээлттэй гэж гэж бодож байна уу. Тэгэхгүй бол нөгөө Үндсэн хуулиа өөрчилнө гэх юм бол өчнөөн дахин олон жил нөгөө цөхөрсөн хүмүүсээ дахин олон жил хүлээлгэх болчихоод. Тэгэхээр тэр яг Үндсэн хууль дээрээ бид нар өөрчлөлт оруулахгүйгээр хүний эрхийн маргааныг тэн дээрээ хийчхэж болно гэдэг Үндсэн хуулийн цэцийн хуулийн концепц тан дээр явж байгаа гэж ойлгож болох уу. Ойлголоо.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн ахлагч Эрдэнэболд гишүүний микрофоныг нээе.

С.Эрдэнэболд: Тогтоол дээр ингэж байгаа юм. Улсын Их Хурлын 2026 оны хаврын чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх гээд А, Б гээд бие даасан механизмын

эрх зүйн орчныг бүрдүүлэх хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын 2026 оны энэ намрын чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх, хохирогчийн эрхийг сэргээх зохицуулалтын хүрээнд эрүү шүүлт, хууль бус баривчилгаа, хилс ял, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчлөөс үүдэн хохирсон иргэдийн эрх сэргээх, нөхөн төлбөр олгох, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн үйлчилгээ үзүүлэх гээд ингээд зорилт болгоод оруулчихсан. Энийг яаж байна гэхээр мэдээж телевизээр энэ хүмүүс үзэж байгаа. Одоо хүртэл тэд нарын хүлээлт маш өндөр байгаад байгаа юм. Ингээд хөөрхий сонсгол болсон. Араас нь Хууль зүйн байнгын хороо ажлын хэсэг гаргасан. Ажлын хэсэг явлаа. Ихэнхтэй нь уулзлаа, учирлаа, сонслоо. Зовлон жаргалыг нь нэг бүрчлэн тэмдэглэж, ойлгож авлаа. Тэгэнгүүт маш их хүлээлт байгаад байгаа байхгүй юу. Тэгэнгүүт Номинчимэг гишүүний хэлээд байгаа үнэн. Ерөнхийдөө системийн асуудал байна гээд тусдаа орхичихоос илүүтэйгээр яг энэ дээр тодорхой үйл ажиллагаа хийе. Гэхдээ .../минут дуусав/

Л.Соронзонболд: Эрдэнэболд гишүүнд нэмэлт 1 минут өгье.

С.Эрдэнэболд: Тэгэхээр би яг нөгөө хохирсон хүмүүстээ л хандаж хэлэх гээд байгаа. Энэ эрүү шүүлтийн улмаас хохирсон гэж байгаа хүмүүстээ онцолж хэлэхэд бол ямар ч байсан өнөөдөр бол энэ тогтоол фундамент буюу суурийг нь тавиад, цаашлаад энэ дээр 1 дүгээрт мэдээж нийгэмдээ энэ алдааг гаргахгүй байх эрх зүйн орчныг нь цэгцтэй болгох ажил явж байгаа ч гэсэн саяын Номинчимэг гишүүний хэлээд байгаачлан энэ хүн нэг бүртэй уулзсан ажил дээр тодорхой ийм шийдэл гаргахын тулд бид нар хугацаа заасан. Энэ оны хавар, намрын чуулгандаа багтааж оруулах гэдэг ийм зорилтыг тавьж байгаа шүү гэдгийг онцгойлон хэлье.

Мэдээж олон нийтэд энэ хурал явж байгаа учраас хэрэг тус бүрээр нь нэг бүрчлэн ийм, тийм байна гэж ярих нь өөрөө хүн хувь хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой. Зарим нууцын зэрэгтэй учраас ярих боломжгүй байгааг хэлье.

Л.Соронзонболд: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Ямар ч байсан тогтоолын төслөө бол дэмжиж байгаа. Тэгэхдээ энийг би бол зүгээр протоколд үлдээсэй гэж бодоод хэлж байгаа. Улсын Их Хурлын тогтоол гарч байгаа. Үүний хэрэгжилтийн араас сайтар явахгүй бол Засгийн газар яг үүнтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг оруулж ирэх энэ хугацаа бол тулаад ирж байгаа. Тэгэхээр энийг бол зайлшгүй бодолцож, аль аль арга хэмжээнүүдийг нь яаралтай хаврын чуулганд байдаг юм уу, намрын чуулгандаа багтааж орж ирэх үү гэдгийг ямар ч байсан протоколоор бол зайлшгүй үлдээе гэж бодож байгаа.

2 дугаарт зүгээр энэ дээр орхигдоод байгаа 1 зүйл энэ хуульч болон хууль сахиулагчдыг бэлтгэх тогтолцооны асуудлыг бид хэд зайлшгүй хармаар юм шиг санагдаад байгаа юм. Яг үнэндээ хэлэхэд жоохон тийм хуучны арга барилаар явахаар энэ хүний эрхийн гэдэг юм уу, бид хэд бол араас нь яваад байгаа. Урьдчилаад хэн болгож бэлтгэх вэ гэдэг энэ боловсон хүчний бодлого дээрээ нэг анхаарч илүү их хүний эрхийн мэдрэмжтэй, бизнес, эдийн засгийн ойлголт энэ тэрийг мэддэг хүмүүс байхгүй бол энэ асуудлуудыг бас мэдлэг дутмаг гэдэг юм уу ийм хүмүүс маань өөрөө эргээд хэрэг хянан хянах ажиллагааны явцдаа бусдын эрхийг зөрчих байдал руу нэлээн орчхоод байна.

Би бол тийм физикли эрүү шүүлт тулгахаасаа гадна бусад зайлшгүй ингэж хугацаагаар уядаг ийм зүйлүүд рүү ингээд явах. Тэгэхээр энэ алба хаагчдын мэдлэг, ур чадвартай холбоотой юмнууд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ зүйл рүү

уг нь нэг тодорхой ахицтай баймаар байна. Миний хувьд Хуульчийн эрх зүйн байдлын хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлаад явж байгаа. Тэгэхээр энийг бол нэг цаашдаа анхааръя.

2 дугаарт хуулиудын суурь шинжтэй өөрчлөлтүүд гэхихсэн байгаа шүү. Энэ бол цаана нь эргээд илэн далангүй ярьдаг бол энэ хууль сахиулах байгууллагуудын тогтолцооны асуудлыг яримаар байгаа юм. Яг энэ формат, энэ тогтолцоогоор явах боломж нь байна уу, үгүй юу. Хүн солиод нэмэр байна уу, үгүй юу гэдэг асуудал хүртэл эргэлзээд байна. Тэгээд хэчнээн сайн хүн томилогдсон ч гэсэн тогтолцоо дээрээ очоод л хууль, эрх зүйн орчноосоо ийм зүйлүүд ингээд гарчхаад байх юм. Тэгэхээр энийг протоколын хувьд Эрдэнэболд дарга хэлчхээч ээ. Энэ суурь зохицуулалтын хүрээнд анхаарах ёстой гэдэг зүйлүүд байгаад байгаа. Тэгэхээр энийг юу гэж ойлгож байгааг протоколд үлдээчихсэн нь зөв байх гэж бодож байна.

Тэгээд яах вэ, гол асуудал бол миний хувьд энэ алба хаагчдыг гэдэг юм уу яг ийм байдал руу түлхэж байгаа тэр удирдах албан тушаалтнуудыг цаашдаа төрийн шат шатны албан тушаалд оролцуулах энэ эрхийг бол ер нь хязгаарламаар юм шиг байгаа юм. Ер нь бол энийг гүйцэтгээд явж байгаа алба хаагчид бол нэг их тийм өөрөө сайн дураараа гэхээсээ илүүтэй улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн шахалт .../минут дуусав/

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн ахлагч Эрдэнэболд гишүүн хариулна.

С.Эрдэнэболд: Сайнзориг гишүүнтэй санал 1 байна. Ер нь эхний хэлсэн зүйл нь болох юм бол нөгөө баахан юм батлаад байдаг, тэгээд хэрэгждэггүй, хэрэгжилтийнх нь араас явдаггүй гэдэг энэ яг үнэн. Ер нь энэ бол маш чухал зүйл хэлээд байгаа юм. Тэгээд нөгөө хэрэгжүүлэхгүй юм уу, эсвэл ашиглахгүй байж байж баахан сүр дуулиантай ингээд тогтоол гаргаад. Түрүүн нэг жишээ хэллээ шүү дээ. Нөгөө хүний эрхийн хүн төвтэй байх парламентын шийдвэр гээд 2024 оны 11 сарын 28-нд гаргасан. Тэгээд жил болгон нөгөө Төрийн байгуулалтын байнгын хороо дээр төлөвлөгөө нь хэлэлцэгдээд, тэр дагуудаа бүх Байнгын хороо болон төрийн салаа мөчрөөр бүгдээр нь тэр нь шалгуур болж явна гэсэн. Одоо эгээд хэрэгжихгүй байгаад байгаа. Бодитоор хэлчихье. Тэгэхээр энэ тогтоол гарахаас өөр арга байхгүй. Тогтоол гарна. Гэтэл тогтоол дээр байгаа зүйлийг хэрэгжүүлэх аягүй чухал байгаад байгаа юм. Тэр ч утгаараа түрүүн Номинчимэг гишүүний гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Тэр хугацаа заасан юм тавиад байгаа. Тэгээд үүнийхээ төл төлөөлөл манай Хууль зүйн байнгын хороо, дэд хороо, ажлын хэсэгт орсон хүмүүс бас итгэл үнэмшил болгож ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа.

2 дугаар хэлсэн санаа дээр санал 1-тэй байна гэж, дэмжиж байгаагаа илэрхийлье.

Л.Соронзонболд: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Тэгээд ямар ч байсан олон жил яриад байгаа. Тэгээд суурь зүйлүүд нь болж өгөхгүй. Би бол бүр ингээд хууль сахиулагч, хуульч бэлтгэх тогтолцооноос л эхлэх ёстой юм байна гэж ер нь харж байгаа. Тэгээд энэ дээр нэг зүйл бол гүйцэтгэх ажлын гэдэг юм уу, нууц мөрдөн шалгалттай холбоотой энэ хууль тогтоомжийг боловсронгуй болгох, 5 сарын 1-ээс энэ тогтолцооны эхлэлийг тавьж байгаа гэж ойлгож байгаа. Өөрөөр хэлэх юм бол энэ Тусгай хяналтын дэд хороо 2 хуваагдаад хууль сахиулах чиглэлийн нууц мөрдөн шалгах холбоотой хяналт бол Хууль зүйн байнгын хороонд ирж байгаа. Тэгэхээр бид хэд идэвхийлэн зайлшгүй

ажиллах, энэ дээрээ илүү фокусалж ажиллах боломж бүрдэж байна гэж харж байна. Тэгэхээр ер нь ийм тогтолцооны зураглалыг зайлшгүй хийж хармаар байна. Тэгээд жишээ нь Солонгос Улс сая нэлээн томоохон хуулийн өөрчлөлт хийлээ л дээ. Law distortion буюу яг хуулийг буруу хэрэглэх, нотлох баримтыг зохиомлоор бүрдүүлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эрүү шүүлт гэдэг юм уу энэ дээр бол маш том Эрүүгийн хуулийн том өөрчлөлт хийгээд, хариуцлагыг чангатгаж .../минут дуусав/

Л.Соронзонболд: Үг хэллээ. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Би бас энэ ажлын хэсгийн гишүүнээр ажилласан. Яг энэ асуудал дээр ажлын хэсэгт ажиллаж байх явцад ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй асуудал үүссэн. Тэгээд тэрийгээ бас ажлын хэсгийнхээ хуралд оролцох болгондоо тэмдэглэлд үлдээгээд явсан. Тэрийгээ би энэ Байнгын хорооны тэмдэглэлд үлдээх нь зөв байх гэж бодож байгаа. Учир нь юу гэвэл миний өөрийн өмгөөлөгч байхдаа ажиллаж байсан хэргүүд энэ дотор орж ирсэн учраас би өмнөх хэргийн материалтай танилцах, хэрэгтэй холбоотой дүгнэлт гаргах гэсэн хэсэг дээр огт орохгүй. Ер нь энэ 30 хэдэн хүний хэргээс сургамж аваад, цаашид яах ёстой юм бэ гэдэг хэсэг дээр нь илүү байр сууриа илэрхийлж, илүү тэр хэсэг дээр нь ажилласан гэдгийг хуралдааны тэмдэглэлд үлдээх нь зөв байх гэж бодож байна. 1 дүгээрт.

2 дугаарт гэвэл түрүүн Номинчимэг гишүүний хэлж байгаа яг үнэн. Тэр хүн яах гэж манай Хууль зүйн байнгын хороонд хандсан юм. Ямар зорилго байгаа юм гэвэл мэдээж эцсийн эцэст энэ хүмүүс эрх бодитой хамгаалагдах ёстой. Тэгээд энэ санал, дүгнэлтээс гадна хэрэг болгон дээр тусдаа дүгнэлтүүд гарсан. Хүн болгон дээр тусдаа дүгнэлтүүд, кэйсүүд дээр нь тусдаа дүгнэлтүүд гарсан. Шинжээчийн дүгнэлтүүд гарсан.

Тэгээд би Тэмүүжин гишүүний хэлсэн дээр нэмээд хэлэхэд яг энэ Дээд шүүх болоод Үндсэн хуулийн цэцийн гээд нөгөө шүүхийн процесс өөрөө үндсэндээ бүрэн дүүрэн дуусаагүй гэж хэлж болно. Тэгэхээр энэ рүү манай Байнгын хороо шууд хэн нэгний нэр төрийг сэргээх эсвэл шинээр илэрсэн нөхцөл байдал мэтээр ингэж бид нар үнэхээр ажиллах боломж байхгүй, ажиллаж ч болохгүй. Тэгэхээр тэр хил хязгаартаа баригдаж, хамгийн байж болох хэмжээнд энэ тогтоол, энэ ажлын хэсгийн дүгнэлтүүд гарч байгаа.

Тэгээд нэгэнт бид нар аль болох хөндлөнгийн хүмүүсээр шинжээчийн багийг бүрдүүлж, нэлээн цаг хугацаа авч, нэлээн хүчин чармайлт гаргаж энэ шинжээчийн дүгнэлт хамгийн байж болох хөндлөнгийн ийм байдлаар гарсан учраас энэ шинжээчийн дүгнэлтүүд маань өөрөө цаашаа дараагийн шүүх эрх мэдлийн хэмжээнд очоод нотлох баримтаар үнэлэгдэх эсэх энэ тэр нь бол дандаа шүүхийн бүрэн эрхийн асуудал болох учраас ингээд манай ажлын хэсэг, дээрээс нь манай Байнгын хороо, дээрээс нь парламентын хувьд бол энэ хүрээд үндсэндээ одоогийн байдлаар үүнээс цаашаа бид нар хил хязгаар давж бол болохгүй байгаа ийм нөхцөл байдал байгаа гэдгийг хэлье.

2 дугаарт бол яалт ч үгүй цаашид гэдэг дээр бид нар онцгой анхаарах ёстой. Тэгээд тогтоолын төсөл дээр бол маш олон асуудлыг дээрээс нь хугацаатай үүрэг даалгавар өгсөн байгаа. Тэгээд энийг харин ёстой Байнгын хорооноос өгсөн хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэх, тэрний биелэлтийг хангах дээр энэ тогтоол 1 номерт орж ирээд, намар бид нар тайлан хэлэлцдэг шүү дээ. Биелэлтийг. Тэгэхэд энийг бол манай Байнгын хороо зайлшгүй шахаж шаардаж ажиллах ёстой ийм

чухал тогтоол байгаа шүү гэдгийг хэлэх гэсэн юм. Тэгээд ажлын хэсгийнхээ бүрэлдэхүүн болоод ажлын хэсгийнхээ ахлагчид баярлалаа гэж хэлье.

Л.Соронзонболд: Үг хэллээ. Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Би протоколд тэмдэглэж үлдээхийн тулд 3 санааг хэлэх гээд байгаа юм.

1 дүгээрт энэ тогтоолын төсөл дээр байгаа 2.3.а байгаа юм. Үнэхээр энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тэнцвэр алдагдчихсан. Бид шүүх эрх мэдэл дээр байх ёстой чиг үүргүүдийг прокурор дээр өгчихсөн. Тэрнээсээ болоод шүүн таслах үйл ажиллагаа ингээд яллах тал руугаа ингээд хэтийдчихсэн байгаа энэ үйлдлийг таслан зогсоохын тулд Засгийн газарт өгч байгаа үүргийн 1 чухал нь бол процессын хуулиа янзлаад, прокурор дээр байгаа зарим чиг үүргүүдийг шүүх рүү шилжүүлэе. Тэгээд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэж ярьж байгаа энэ процессын шүүхийн хяналтыг илүү оновчлох ажлаа бодлогын түвшинд хийгээч гэдэг энэ даалгаврыг өгч байгаа. Энэ бол тогтолцооны хувьд бол маш том дэвшил болно.

2-т нь бол яах аргагүй тэр 2.4 дээр байгаа. Энэ эрүү шүүлт тулгасан, хууль зөрчиж өөрсдөө гэмт хэрэг үйлдэж, гэмт хэрэгтэй тэмцэж байгаа энэ албан хаагчдын хар жагсаалтыг үйлд. Энэ хар жагсаалтад орсон хүмүүсийг дахиад тэр алба руу зүглүүлдэггүй байх, албан тушаал дээшлүүлдэггүй байх, хүний эрхэд халддаг энэ ажил дээр нь буцаагаад авчирдаггүй байх ийм хариуцлагын тогтолцоо өөрөө бүрдэх ёстой. Тендер будилаантуулбал тендерийн хар жагсаалт гэж аж ахуйн нэгж дээрээ хийж болоод байгаа мөртөө төрд төрийн нэрээр гэмт хэрэг үйлдэж байгаа хүмүүсийг хар жагсаалтад оруулдаг, энэ цэвэрлэгээ хийдэг систем чинь байх ёстой шүү дээ. Дээр нь тэр хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас болоод төр хохироод яваад байж болохгүй. Хохирсон иргэдэд нөхөн төлбөр олгож байгаа мөнгийг буцаагаад тэр буруутай этгээдүүдээс нь гаргадаг тогтолцоогоо бүрдүүл. Тэгэхгүй төрийн нэр бариад, хууль барьж хүнийг хэлмэгдүүлчхээд өмнөөс нь төр эдийн засгийн хувьд дахиж давхар хохироод, татвар төлөгчид хохироод яваад байдаг ийм тогтолцоо ерөөсөө байж болохгүй. Энэ зарчим хэрвээ амилбал эрүү шүүлттэй холбоотой асуудлын хамгийн чухал хэсэг нь болно.

Энэ 2.а дээр бичигдчихсэн байгаа зүйлийг жоохон тодруулах хэрэгтэй байна. 2 дугаар зүйл дээр ташуу зураас 2 байгаа шүү. Тэн дээр дахиад Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.1 тэр зүйлийг бичмээр байна. Дурдмаар байна. Тэр зүйл чинь юу байгаа вэ гэхээр иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх эрх мэдлийг Үндсэн хуулийн цэцэд олгож, Үндсэн хуулийн цэцийг Үндсэн хуулийн шүүх болгох чиглэлийн зорилт байгаад байгаа юм. Энэ зорилтыг хэрэгжүүлээд аваад явбал саяын энэ хохирсон гээд байгаа иргэд үндсэн эрхийнхээ маргааныг Цэцэд өгөх замаар буцаагаад шүүх дээр гарсан алдааг засуулах боломжтой болох байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлыг хууль тогтоогчийнхоо хувьд шийд гэдэг даалгавруудыг Засгийн газартаа өгөхөөс гадна энэ 2 дахь хэсгийн “а”-д байгаа зүйлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг .../минут дуусав/

Л.Соронзонболд: Тэмүүжин гишүүний микрофоныг нэмж 1 минут.

Х.Тэмүүжин: 2 ташуу зураасны “а”-д байгаа тэр зүйлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах шинэ алба байгуулах гэдгээр нь бүр тодорхой бичмээр байна. 1.

2-т нь Үндсэн хуулийн цэцийг иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэдэг Үндсэн хуулийн шүүх болгох чиглэлд гэж тодорхой бичмээр байна. Ингэж биччихвэл хэмжихэд тодорхой, шаардахад тодорхой. Дараа нь бид энэ ажил хаана байна гээд зохион байгуулалтаа хийхэд илүү үр дүнтэй болно.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн ахлагч Эрдэнэболд гишүүн хариулъя.

С.Эрдэнэболд: Тэмүүжин гишүүний саналыг зарчмын хувьд дэмжиж байна. Тэгээд яг энийг редакцтайгаар батлах саналтай байна. Тэгээд өөрөө ажлын хэсэгт орсон. Яг энэ төсөл боловсруулахад орсон учраас энийг редакцтайгаар батлаад яг энэ найруулгаар нь дэмжихэд зарчмын хувьд асуудалгүй гэж үзэж байна.

Л.Соронзонболд: Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара: Эрүүдэн шүүхийн эсрэг сонсгол явагдаад, бүтэн 2 өдрийн туршид маш олон иргэдийн өнгөрсөн жилүүдэд болсон гомдол, шаналал, зовлон бэрхшээл бүх зүйлүүдийг бид нар сонсож байсан. Тэгээд үүнтэй холбоотой нийт хэлмэгдсэн иргэдийн гаргасан өргөдөл материалд шинжээч томилж ажиллуулахад ер нь бол эрүүдэн шүүсэн, эрхийг нь зөрчсөн байж болзошгүй ийм тохиолдлууд, байдлууд бол тогтоогдсон байгаа. Тэгээд энэ тогтоолын хүрээнд ер нь манай парламентын эрх хэмжээний хийж авч явах юмнууд нь жишээлбэл юу гэдэг юм гэм бурууг нь нягтлаад цагаатгах ажлыг хуулийн дагуу хөндлөнгийн нөлөөгүй явуулах ийм эрх зүйн зохицуулалтуудыг бий болгох боломж бидэнд байдаг юм болов уу.

2 дугаарт нөгөө нэг эрүүдэн шүүхийг чинь мэдээж эрх мэдэл бүхий субъектүүд л хийж байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг өнгөрсөн хугацаанд жишээлбэл АТГ-ын байцаагч гэх үү юу гэх вэ, ингээд эрүүдэн шүүсэн байж болзошгүй. Нөгөө хүн нь болохоор зэрэг хоригдох хугацаандаа эрүүл мэндийн ямар нэгэн шалтгааны улмаас нас барсан. Гэтэл эргээд тэр хүнийг ямар арга хэмжээ авсан бэ гэхэд бол ажлаас халсан гэдэг ийм л зүйлээр ингээд дуусдаг. Тэгэхээр зэрэг энийг нөгөө эрүүдэн шүүх гэмт хэрэгт холбогдсон ажилтан, албан тушаалтныг төрд ажиллуулахгүй байхын тулд энэ хууль дээр бараг энэ Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь хэсэгт нөгөө төрийн жинхэнэ албан хаагчид нь тавигдах нийтлэг шаардлага Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байгаагүй гэдэгт эрүүдэн шүүх гэмт хэрэг гэж нэмэлтээр оруулбал яадаг юм бэ. Тэгэхгүй бол энэ чинь өөрөө нэг ийм тодорхой хуулийн цоорхой байгаад зөвхөн ажил, албан тушаалаа өгсөн байдалтайгаар дуусгаад, дараагийн дахиад төрийн албанд томилогдоод ажиллаад байдаг ийм зүйлүүд гараад байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг энийг ингэж Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах маягаар шийдвэрлэх боломж байгаа юм биш үү гэж асуумаар байна.

Л.Соронзонболд: Нарантуяа-Нара гишүүний асуултад ажлын хэсгийн ахлагч Эрдэнэболд хариулна.

С.Эрдэнэболд: Тийм ээ, яг энийг нөгөө Дамдины Цогтбаатар гишүүн бид нар ер нь яриад байгаа юм. Олон улсын ийм жишиг байна. Тэгээд яг ийм төрлийн асуудал дээр хөөн хэлэлцэх хугацаагүйгээр ер нь авч үздэг байя энэ тэр гэсэн юм яриад байгаа юм. Тэгэхдээ яг энэнтэй холбогдохгүйгээр ер нь бие даасан ийм зохицуулалттай хуулийн төсөл байя гээд л яриад байгаа. Тэмүүжин гишүүн ч гэсэн бас энийг ярьж байгаа. Ер нь бол бид нар энийг ингээд яриад байгаа юм.

Тэгэхээр одоо нөгөө яг энэ энийгээ нэг сагсанд бүгдийг нь хийчих гэхээр их тийм учир замбараагүй болчих гээд байгаа учраас ямар ч байсан эхний ээлжид энэ тогтоол гараад, түрүүний Баасанжаргал гишүүний хэлээд байгаачлан нөгөө бид нар чинь нэг ийм хүрээн дотор явахгүй бол зарим хэрэг нь шүүх дээр эцэслэгдэж дуусаагүй байгаа. Зарим хэрэг нь процесс дундаа явж байгаа юман дээр бид нар шууд энэ нь зөв байна, тэр нь буруу байна, ингэсэн байна, тэгсэн байна гэдэг дүгнэлт гаргаад, хууль, шүүхийн байгууллагад хөндлөнгөөс нөлөөлөх нь өөрөө эрх зүйн хувьд ч тэр ерөөсөө боломжгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр бид нар бол яаж байгаа вэ гэхээрээ нөгөө энэ экспертүүдийн авсан дүгнэлтээс үндэслээд энэ тогтоол гаргаад, тогтоол дотор энэ хуулиуд ярих явцад хууль тус бүрийнх нь ч гэдэг юм уу тэр доторх концепц дотор нь харин ингэж болохгүй юм байна гэдэг юм байгаа.

2 юм байгаа. 1 нь болохоор ирээдүйд энэ төрлийн юманд давтагдахгүй байх эрх зүйн орчныг яаж боловсронгуй болгох вэ гэдэг ерөнхий 1 ийм системийн шинж чанартай зүйл, нөгөөдөх нь болохоор яг энэ нөгөө кэйс болгон чинь бид нарт ингээд судлагдахуун болчихлоо шүү дээ. Энэ судлагдахуун болгон дээр хэрвээ тэр хуулийн орчин маань бий болж байж явах л юм байгаа юм. Шулуухан хэлэхэд жоохон хугацаа туулах л юм байгаад байгаа юм. Тийм учраас хэзээ нэгэн цагт гэж ярихгүйн тулд бид нар энэ хавар, намрын чуулганы хүрээнд энэ асуудлыг судалж шийдье. Их Хурал руу ороод хаячих биш, бид нар чинь өөрсдөө Их Хурлын гишүүд учраас энэ дээрээ ч гэсэн санаачилгатай ажиллая л гэдэг юм одоо байгаа боломжоо тултал нь л ашиглаж байгаа л хувилбар байгаа.

Л.Соронзонболд: Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Мэдээж шүүхийн шийдвэрт хөндлөнгөөс нөлөөлөх ч юм уу, шүүхийн шийдвэрийг бид нар ямар нэгэн байдлаар өөрчлөх гээд байгаа асуудал бол ерөөсөө байхгүй. Гагцхүү бид нарт бол Улсын Их Хуралд бол хуулийг ялангуяа энэ цаг үе, нөхцөл байдалд нийцсэн, шинэ цаг үеийн нөхцөл байдлаар өөрчлөх тэр эрх мэдэл нь байгаа шүү дээ. Тэгэхээр ерөөсөө энэ цоорхой орхигдоод байгаа ялангуяа эрүүдэн шүүсэн гэмт хэрэг үйлдсэн субъектүүд дараа дараагийн төрийн албанд ажиллаад байгаа энэ нөхцөл байдлыг бид нар өөрчлөхийн тулд Төрийн албаны тухай хуулийн тэр зүйл заалтад нь л ийм нэмэлт, өөрчлөлт оруулъя гэж байгаа байхгүй юу. Жишээлбэл, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй гээд энэ дээр чинь нэмээд эрүүдэн шүүх гэмт хэрэг үйлдэж байгаагүй гэдэг ч юм уу. Ингэж оруулах ийм санал байгаад байгаа байхгүй юу.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн ахлагч Эрдэнэболд гишүүн хариулъя.

С.Эрдэнэболд: Нара гишүүнтэй санал нэг байна. Дэмжиж байна. Та энийгээ бас Их Хурлын гишүүнийхээ хувьд хууль санаачлах субъектийнхээ хувьд оруулаад, тэгээд хэдүүлээ энийг хамтраад шийдвэр гаргаад явъя.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Тулгаас санал ирсэн.

“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх санал.

“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмэх:

“1.Эрүүдэн шүүх гэмт хэрэг үйлдсэн этгээдийг төрийн албанд ажиллуулахгүй байх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь хэсэгт заасан төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах нийтлэг шаардлагад эрүүдэн шүүх гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх гэсэн нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

2.Хэлмэгдсэн иргэдийн гаргасан өргөдөл гомдолд үндэслэн хийсэн шинжилгээ, шинжээчийн дүгнэлтээр эрүүдэн шүүсэн, хүний эрхийг зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсонтой холбогдуулан:

а/тухайн иргэдийн эрх зөрчигдсэн нөхцөл байдлыг тогтоож дүгнэлт гаргах, нийтэд ил тод мэдээлэх үүрэг бүхий ажлын хэсэг эсхүл түр хороо байгуулах

б/Уг ажлын хэсэг, түр хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн тухайн хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын үндэслэлээр дахин хянан шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулах.

3.Эрүүдэн шүүх болон хүний эрх зөрчсөн байж болзошгүй хэрэг, маргааныг хянан шалгах, дахин хянан шийдвэрлэх ажиллагааг хөндлөнгийн нөлөөгүй, хараат бус байдлаар явуулах эрх зүйн орчин нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тулга.

Энэ бол Тулга гишүүний санал байгаа.

Тэгэхээр Их Хурлын тогтоолын төслөө ажлын хэсгийн ахлагч Эрдэнэболд гишүүн уншаад танилцуулчих.

С.Эрдэнэболд: Тулга гишүүний саналыг уншихаар жишээлбэл хэрэг тус бүрээр ингээд бид нар дүгнэлт гаргана гэхээр чинь төвөгтэй байхгүй юу. Яагаад гэхлээр тэр чинь процессын шатад явж байгаа юман дээр бид шүүхийн ажлыг булааж авах гээд ч байгаа юм шиг. Тэгэхдээ дотор нь ерөнхий агуулгын хувьд энэ дотор орчихсон юмнууд байгаа байхгүй юу. Тэгэхээр би тогтоолын төслийг редакцтай уншаадахъя гэж байгаа юм. Тэгээд та бүхэн яг энэ тарааж өгсөн учраас харчхаарай. Сая Тэмүүжин гишүүний өгсөн саналыг би дунд нь редакцтай уншихъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах арга хэмжээний тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нотлох баримтыг бүрдүүлэх, үнэлэхэд гарч буй алдаа завхрал, хууль зүйн туслалцаа авах эрхийг зөрчиж хязгаарлаж буй явдал, хүний халдашгүй байдал зөрчигдөх нөхцөл байдал арилахгүй байгаа төдийгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль зөрчсөн шийдвэр, шүүхийн хараат бус байдалд эргэлзээ үүсэх нөхцөл, цагдан хорих, таслан сэргийлэх, таслан сэргийлэх арга хэмжээний хэт хэрэглээ нь нэг бүрчилсэн алдаа бус системийн шинжтэй доголдол мөн болохыг тэмдэглэж, эдгээрийг арилгах, хүний эрхийн баталгааг бодитоор хангах зорилгоор дараах бодлогын зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ням-Осорын Учрал-т даалгасугай.

1/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийн суурь баталгааг бодитоор хангах зорилгоор дараах арга хэмжээг шалгуур үзүүлэлт, тогтмол хяналт шинжилгээ, хариуцлагын тогтолцоонд тулгуурлан хэрэгжүүлэх:

а/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчгүйгээр байцаалт явуулах, мэдүүлэг авах аливаа практикийг бүрэн таслан зогсоож байцаалт бүрийг өмгөөлөгчийн оролцоотой явуулсан эсэхийг бүртгэлжүүлэх, зөрчлийн тохиолдлыг улирал тутам тайлагнах, илэрсэн зөрчил, сахилгын болон эрх зүйн хариуцлага ноогдуулах нэгдсэн журам баталж мөрдүүлэх;

б/цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хэрэглээг хуульд заасан үндэслэл шалгуурт нийцүүлэн хатуу хязгаарлах, цагдан хорих шийдвэрийн үндэслэл, хугацаа, сунгалтыг нэгдсэн сангаар бүртгэх, сар бүрийн хяналт шинжилгээгээр шалгуурт нийцээгүй тохиолдлыг илрүүлж бууруулах зорилтот үзүүлэлт тогтоох үндэслэлгүй хэрэглэсэн тохиолдолд хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх;

в/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрүү шүүлт тулгаж бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж, мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй байх хуулийн хэрэгжилтийг хангаж ийнхүү олж авсан нотлох баримтыг шүүхийн шатад хассан тохиолдлын тоо, үндэслэл, шалтгаан, холбогдох этгээдэд хариуцлага тооцсон эсэх талаар тогтмол нэгтгэн дүгнэж байх, прокурорын хяналтын шатад нотлох баримтын хууль ёсны байдлыг урьдчилан хянах механизмыг бүрдүүлэх;

г/хэрэг хаах, сэргээх, хөөн хэлэлцэх хугацаа тооцох асуудлаарх хууль хэрэглээний зөрөө арилгах зорилгоор нэгдсэн тайлбар, аргачлал батлан мөрдүүлэх, шүүх, прокурорын байгууллагын практикт гарч буй зөрүүг хагас жил тутам буюу 6 сард нэгтгэн дүгнэж, шаардлагатай тохиолдолд тайлбар, аргачлалыг шинэчлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулах;

д/прокурор, мөрдөгчийн хүний эрхийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг системтэйгээр дээшлүүлэх хүрээнд сургалтыг жил бүрийн батлагдсан хөтөлбөрөөр тогтмол зохион байгуулах, оролцоо, үнэлгээ, ахицын шалгуур үзүүлэлт тогтоох, хяналт, шинжилгээ, гүйцэтгэлийн үнэлгээг хүний эрхийн шалгууртай уялдуулж, сахилга хариуцлагын тогтолцоог бодитойгоор хэрэгжүүлэх.

2/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2024 оны 41 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.1.1.1 буюу энэ нь сая Тэмүүжин гишүүний редакц оруулсан иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх эрх мэдэл хуваарилалтын хяналт тэнцлийн хангуулах чиглэлээр Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг тодотгоно гэсэн энэ агуулга явж байгаа юм байна. 4.2.1.14-д “гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатад гаргана” гэж заасныг хэрэгжүүлэх хүрээнд дараах асуудлыг тусгаж, холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2026 оны хаврын чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх.

Энд манайхан хугацаа зааж байгааг анзаарч байгаа байх.

3/Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг шалгах алба байгуулахаар хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2026 оны намрын чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх. Энэ дахиад хугацаа зааж байна шүү манайхан анхаараарай.

Тэгээд хохирогчийн эрхийг сэргээх зохицуулалтын хүрээнд эрүү шүүлт, хууль бус баривчилгаа, хилс ял, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчлөөс үүдэн хохирсон иргэдийн эрх сэргээх, нөхөн төлбөр олгох, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үүсээд буй тэнцвэр алдагдсан, яллах чиг баримжаа давамгайлсан тогтолцоог өөрчилж, хүний эрхийн баталгааг бодитоор хангах зорилгын хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цогц шинэчлэлийн саналыг боловсруулж, Улсын Их Хурлын 2026 оны намрын чуулганы хугацааны хугацаанд Хууль зүйн байнгын хороонд танилцуулах.

а/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дээд шатын прокурорт гомдол гаргаж шийдвэрлүүлэх зохицуулалт байгааг өөрчилж, прокурорын зарим чиг үүргийг шүүхэд шилжүүлэн, мөрдөн шалгах ажиллагаа дахь шүүхийн хяналтыг оновчлон, прокурор, өмгөөлөгчийн шүүхийн өмнө тэгш байх зарчмыг хангах;

б/өмгөөллийн үйл ажиллагааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бодит нөлөө үзүүлэх, бие даасан хүний эрхийн хамгаалалтын механизм болох чиглэлд өөрчилж, өмгөөлөгчийн оролцооны зайлшгүй байдлыг хангах хууль зүйн туслалцаа бодитоор хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

в/мөрдөгч, прокурорын зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан хүний эрхийн болон хуулийн зөрчилд ноогдуулах хариуцлага зайлшгүй байх механизмыг бий болгож, ил тод, үр нөлөөтэй хяналт шинжилгээ, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх.

2.Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийн хохиролд төрөөс нөхөн олгосон төлбөрийг тухайн гэмт хэргийг үйлдсэн буруутай этгээдээр буцаан төлүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, /энэ Нара гишүүний хэлээд байгаа зүйтэй хамааралтай зүйл ярьж байна шүү./ уг гэмт хэргийг үйлдсэн этгээдийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийг бий болгохын тулд нийцүүлэн хөтлөх, ашиглах журмыг баталж ../минут дуусав/

Л.Соронзонболд: Эрдэнэболд гишүүнд нэмж 1 минут өгье.

С.Эрдэнэболд: Тэгэхээр яг энэ хэсэг дээр нь тэр юуг бол оруулж болж байна гэж байгаа юм. Одоо 1 минутад багтчихна.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг эрүүдэн шүүх гэмт хэрэг болон хүний эрх, эрх чөлөөний зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүний эрхийн боловсрол, мэргэжлийн ёс зүй, хууль дээдлэх зарчимд суурилсан тасралтгүй сургалт, давтан бэлтгэлийг тогтмол зохион байгуулж, мөрдөн шалгах ажиллагаанд хууль бус арга хэрэглэхийн хууль зүйн үр дагавар, хор уршгийг бодит кэйсээр ойлгуулан байцаалт, мэдүүлэг авах ажиллагаанд бичлэгжүүлэлт, өмгөөлөгчийн оролцоог хангах талаарх сургалт, хяналтыг сайжруулж, алба хаагчдын хууль зөрчих нөхцөлд хүргэдэг ажлын ачаалал, гүйцэтгэлийн дарамтын хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр зохион байгуулалттай арга хэмжээ авах.

Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан зохион байгуулалтын болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинээр бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Улсын Их Хурлын 2026 оны хаврын чуулганы хугацаанд Хууль зүйн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, тогтоолын хэрэгжилтийн талаарх парламентын хяналтын сонсголыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай гэсэн төсөл байна.

Тэгээд редакцтайгаар уншсан шүү сая.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн ахлагч Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Тэгэхээр тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Тулгаас гаргасан саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Улсын Их Хурлын гишүүн Тулгын гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 20 гишүүнээс 4 гишүүн дэмжиж, 20 хувийн саналаар Улсын Их Хурлын гишүүн Тулгын санал дэмжигдсэнгүй.

Ажлын хэсгийн ахлагч Эрдэнэболд гишүүнд микрофон өгье.

С.Эрдэнэболд: Алтангэрэл гишүүн ээ, Уянгахишиг гишүүн ээ, ийм шүү. Энэ нөгөө Тулга гишүүний гаргасан саналыг дэмжихгүй болоод унагаагаад байгаа биш буюу гол санаанууд нь энэ тогтоолын төсөлд орчихсон. Манай Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн байнгын хорооны гишүүд тогтоолын төсөлтэй танилцчихсан бөгөөд Тулга гишүүн Хүний эрхийн дэд хороонд байхгүй байгаа шүү дээ. Хүний эрхийн дэд хороонд танилцуулчихсан. Уучлаарай. Ажлын хэсэгт байхгүй. Би 2 юм яриад байна шүү дээ. Дэд хороо, ажлын хэсэгт орсон хүмүүс нь танилцчихсан, бусад нь танилцаж амжаагүй байсан бөгөөд ингээд өгсөн юм байна. Тэгэхээр Тулга гишүүний гаргасан зарчмын саналууд тогтоолд агуулгын хувьд орчихсон гэж үзээд давхцал үүсгэхгүйн тулд сая ингэсэн шүү. Тэрнээс биш юу гэдэг юм нөгөө саналыг нь унагаж байгаа зүйл биш. Агуулгын хувьд орчихсон гэдгийг л хэлж байгаа. Нэгэнт зарчмын зөрүүтэй санал ирсэн учраас санал хураалт явагдлаа гэдгийг онцлон тэмдэглэе.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулж санал хураалт явагдана. Гишүүд санал хураалтаа бэлдье. Санал хураалт. 20 гишүүнээс

11 гишүүн дэмжиж, 55 хувийн саналаар хууль Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжлээ.

“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 10 дугаар тогтоолоор байгуулагдсан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, санал, дүгнэлт гаргах шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болж, ажлын хэсгийг хаасныг мэдэгдье. Ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд баярлалаа.

15.53 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

“Журам шинэчлэн батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна.

Б.Баярбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн 5-ыг нь шүүгчид дотроосоо сонгож, бусад 5 гишүүдийг нь нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь 4 жилийн хугацаагаар зөвхөн 1 удаа ажиллах бөгөөд зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын Дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.” гэж, 6 дахь хэсэгт “хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.11 дэх хэсэгт “Ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулахтай холбоотой журмыг энэ хуульд нийцүүлэн Байнгын хороо баталж, Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна.” гэж, 95 дугаар зүйлийн 95.7 дахь хэсэгт “сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулж, томилох ажиллагаанд хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах журмыг Байнгын хороо энэ хуульд нийцүүлэн батална.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоол баталсан бөгөөд уг журамд заасны дагуу нийт 3 удаагийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийг тодруулж, Улсын Их Хуралд нэр дэвшүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд зохион байгуулагдсан нэр дэвшигчийн томилгооны сонсголыг явуулах үед болон уг асуудлыг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Байнгын хорооны гишүүдээс дээрх журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах, боловсронгуй болгох тухай санал гаргасныг нэр дэвшигчид томилгооны сонсголын тайланд тусгасан байна.

Үүнтэй холбоотойгоор Байнгын хороо ажлын хэсэг байгуулах тухай 2026 оны 1 дүгээр тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоолоор баталсан журмыг сайжруулж, хуульд нийцүүлэх чиглэлээр санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, гишүүдэд Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Д.Ганбат, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг нар ажилласан болно.

Ажлын хэсэг журмыг хуульд нийцүүлэх, боловсронгуй болгох зорилгоор гишүүдийн саналыг бичгээр авч нэгтгэсэн бөгөөд 2 удаа хуралдаж, журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа. Үүнээс зарим онцлог, зохицуулалтын талаар дурдвал,

1. Журмын үйлчлэх хүрээ, хязгаарыг хуульд нийцүүлэн тодорхойлсон.

2. Шүүгч бус гишүүнд нэр дэвших хүсэлт гаргасан иргэнээс шаардах баримт бичгийн зохицуулалт нь давхардсан агуулгатай болон хуульд заагаагүй нэмэлт шаардлага тусгагдсан байсныг хуульд нийцүүлэн өөрчилсөн.

3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажиллагааны онцлогийг харгалзан ялгаатай байдлаар зохицуулахаар өөрчилсөн.

4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилоход сонголт хийх шаардлагатай зарим этгээдийн төлөөллийг Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургууль гэх байдлаар шууд нэрлэн заасан байсныг хуульд нийцүүлэн өөрчилсөн.

5. Нэг нэр дэвшигчийг 2 илтгэгч гишүүн хариуцан ажиллах зохицуулалтаар тусгасан.

6. Хуульд заасан зарим асуудлыг журамд ерөнхий байдлаар тусгасан байсныг нарийвчилж сонгон шалгаруулалтын үе шат, дараалал үйл ажиллагааны процессын зохицуулалтыг тусгасан.

7.Ил тод байдал, олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг хэлбэрийн шинжтэй байсныг өөрчилж, сонгон шалгаруулалтыг мэдээлэх, нэр дэвших тухай хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, ашиглах журмыг тодорхой болгосон.

8.Ажлын хэсгийн үйл ажиллагаа, хуульд заагаагүй хориглох зохицуулалт тусгагдсан байсныг хасаж, ажлын хэсгийн гишүүдийн бүрэн эрх, үүргийг тодорхойлсон зохицуулалтыг тусгасан.

9.Журмын бүтэц, найруулгыг хууль зүйн техникийн шаардлагад нийцүүлэн өөрчилсөн.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Л.Соронзонболд: Баярмагнайн Баярбаатар гишүүнд баярлалаа. Байнгын хорооны тогтоолын төсөл болон журмын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын болон журмын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

“Журам шинэчлэн батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 20 гишүүнээс 11 гишүүн буюу 55 хувийн саналаар Байнгын хорооны тогтоолын төсөл дэмжигдлээ. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмыг сайжруулж, хуульд нийцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болж ажлын хэсгийг хаасныг мэдэгдье. Ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд баярлалаа.

16.02 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна.

Г.Уянгахишиг: Горимын санал гаргая. Ерөнхийдөө яг энэ асуудлаар ажлын хэсэг болон дэд ажлын хэсэг олон удаа хуралдсан. Ажлын хэсэг 3 удаа, дэд ажлын хэсэг 6 удаа хуралдаад байна. Гэхдээ яг нийслэлээс гаргаж өгөх ёстой мэдээллүүд буюу тухайн яг ямар майпинг буюу газрын зураглалаар дугуйн замтай юм, ямар авто зам дээр тусгай зурвас хийх боломжтой юм гэдэг энэ асуудлыг бараг бүтэн жил бид

нар ажлын хэсэг дээрээ шаардсан боловч мэдээлэл одоохондоо гарч ирээгүй байна. Өнөөдрийг хүртэл. Дээрээс нь яг ажлын хэсгийн хурлууд дээр нийслэлээс төлөөлөгчид ерөөсөө ирэхгүй байгаа. Тэгэхээр энэ асуудал өөрөө нийслэлтэй маш уялдаатай явах ёстой ажил. Тийм учраас хэдийгээр явган зам дээрээс мопед, скутер явахыг хориглож болж байгаа боловч авто зам дээр гарахад аюулгүй байдлын хангалт байхгүй. Нийслэл өнөөдөр өөрөө дэд бүтцээ шийдэж чадаагүй ийм нөхцөл байдалтай байгаа учраас яг энэ ажлын хэсгээр зарчмын зөрүүтэй саналууд дээрээ бас ажлын хэсгийн гишүүдийн зүгээс дахиж ярилцах шаардлагатай байна гэдэг ийм шаардлага үүсээд байгаа учраас тодорхой хугацаагаар 7 хоног юм уу, 14 хоногоор хойшлуулах хүсэлтэй байгаа юм.

Тэгэхээр өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хасуулаад, хойшлуулах горимын санал гаргаж байна.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн ахлагч Уянгахишиг гишүүний горимын саналаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Дэмжье гэснээр санал хураалт явуулъя. Санал хураалт. Отгонбаяр гишүүнийг орохгүй байна. Санал хураалт 20 гишүүнээс 11 гишүүн буюу 55 хувийн саналаар Уянгахишиг гишүүний горимын санал дэмжигдэж, хойшлуулах санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

16.05 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ